



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

**ӨМГӨӨЛӨГЧИЙН МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙН
ХАРИУЦЛАГА, ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ
МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭЖ БУЙ
ПРАКТИК, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ**

Улаанбаатар
2023

ННА 67
ДАА 340
У-711



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

ӨМГӨӨЛӨГЧИЙН МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙН ХАРИУЦЛАГА, ТҮҮНТЭЙ
ХОЛБООТОЙ МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ПРАКТИК,
ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Бодлогын судалгаа

Судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн: Э.Уянга

© Нээлттэй Нийгэм Форум, 2023

Хаяг: Жамьян гүний гудамж
Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар 14240
Утас: 976-76113207
Веб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn

Энэхүү судалгааны дүгнэлт, санал нь хийж гүйцэтгэсэн судлаачдын
байр суурь бөгөөд Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр
суурийг илэрхийлэхгүй болно.

ISBN 978-9919-9083-1-7

ӨМНӨХ ҮГ

Нээлттэй Нийгэм Форум Эрх зүйн хөтөлбөрийнхөө хүрээнд хуульчдын өөрөө удирдах байгууллагыг бэхжүүлэх, өмгөөлөгчдийн чадавхыг сайжруулах, тэдний мэргэжлийн хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр холбогдох талуудад сургалт, судалгааны дэмжлэг үзүүлж ирлээ.

Өмгөөлөгчдийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг баталгаажуулах, мэргэжлийн хариуцлагыг нэмэгдүүлэх нь иргэдийн шударгаар шүүлгэх эрхийг баталгаатай эдлүүлэхэд нэн чухал үр нөлөөтэй. Иймээс манай байгууллага цөөнгүй бодлогын судалгааг дэмжин нийтийн хүртээл болгоод байна. Энэ удаад Э.Уянга судлаачийн хийж гүйцэтгэсэн “Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн хариуцлага, түүнтэй холбоотой маргаан шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудал” сэдэвт судалгааны ажлыг танилцуулж байна.

Судлаач Э.Уянга манай улсад хүчин төгөлдөр хэрэгжиж буй холбогдох хууль тогтоомж, түүний хүрээнд шийдвэрлэгдэж буй өмгөөлөгчтэй холбоотой мэргэжлийн хариуцлагын маргаан шийдвэрлэх механизмд дүн шинжилгээ хийхийн зэрэгцээ Герман, Япон, Америк зэрэг орны тогтолцоог харьцуулан судалж санал зөвлөмж боловсруулсан байна.

Энэхүү судалгааны тайланг Монголын өмгөөлөгчдийн холбоо болон Монголын хуульчдын холбоо зэрэг хуульчдын өөрийн удирдлагын болон нийтийн эрх зүйн байгууллагууд, өмгөөлөгч, хуульчид анхааран авч үзэж, санал зөвлөмжийн хүрээнд үр дүнтэй хэлэлцүүлэг өрнүүлнэ гэж найдаж байна.

Эрх зүйн болон засаглалын чиглэлээр бидний эрхлэн нийтэлсэн бусад судалгааны ажилтай www.forum.mn цахим хуудаснаас танилцан, түгээн дэлгэрүүлэхийг хүсье.

ННФ-ын Гүйцэтгэх Захирал П.Эрдэнэжаргал

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	3
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ:.....	5
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	5
УДИРТГАЛ.....	6

НЭГ. ӨМГӨӨЛӨГЧИЙН МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙН ХАРИУЦЛАГЫН МЕХАНИЗМ	9
1.1. Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүй	9
1.2. Өмгөөллийн үйл ажиллагааны мэргэжлийн ёс зүйн хариуцлага	18

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ӨМГӨӨЛӨГЧИЙН МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙН ХАРИУЦЛАГЫН МЕХАНИЗМ, ПРАКТИКТ ТУЛГАМДСАН ЗАРИМ АСУУДАЛ.....	25
2.1. Өмгөөллийн маргаан шийдвэрлэх ажиллагаанд холбогдох эрх зүйн зохицуулалт.....	25
2.2. Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн хариуцлагын өнөөгийн байдал.....	27
2.3. Хууль тогтоомжийн хэрэгжилт, тулгамдсан зарим асуудал.....	34

ГУРАВ. ГАДААД ОРНЫ ТУРШЛАГА.....	44
3.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс.....	44
3.1.1. Сахилгын хэрэг хянан шалгадаг институт, сахилгын шийтгэл	44
3.1.2. Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа	46
3.2. Америкийн Нэгдсэн Улс	50
3.2.1. Сахилгын хэргийг хянан шийдвэрлэдэг институт, сахилгын шийтгэл	51
3.2.2. Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа	52
3.3. Япон улс	55
3.3.1. Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх институт, сахилгын шийтгэлийн төрөл.....	56
3.3.2. Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа	57

ДҮГНЭЛТ.....	61
---------------------	-----------

САНАЛ, ЗӨВЛӨМЖ.....	63
----------------------------	-----------

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ.....	66
----------------------------------	-----------

ХАВСРАЛТ.....	69
Хавсралт 1. “Монгол үндэсний ёс суртахууны үнэт өвөөс”	69
Хавсралт 2. Ёс суртахууны зохицуулалтын агуулга, аргын харьцуулалт	71
Хавсралт 3. Өмгөөлөгчид хүлээлгэсэн хариуцлага.....	72

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ:

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
МУИС	Монгол Улсын Их Сургууль
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1.	Гомдол шийдвэрлэсэн байдал (2021 он).....	29
График 2.	Маргаан үүсгэсэн хэргийг шийдвэрлэсэн байдал (2021 он) ...	30
График 3.	Гомдол шийдвэрлэсэн байдал (2022 он).....	31
График 4.	Мэргэжлийн хариуцлагын хороонд ирүүлж буй гомдлын агуулга.....	35
График 5.	Судалгаанд оролцогч (аймгаар).....	36
График 6.	Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин.....	36
График 7.	Хүний эрхийн зөрчил.....	37
График 8.	Хүний эрх зөрчдөг этгээд.....	38
График 9.	Хууль зүйн туслалцаа авах эрх.....	39
График 10.	Өмгөөлөгчөөс туслалцаа авч байсан эсэх.....	39
График 11.	Өмгөөлөгчийн ёс зүйд өгөх үнэлгээ.....	40
График 12.	Өмгөөлөгч хараат бусаар хуульд захирагдан ажилладаг эсэх.....	41
График 13.	Хууль хэрэгжихгүй байх шалтгаан.....	42
График 14.	Хуулийн үйлчлэл.....	42
Шигтгээ 1.	1964 онд Монголын Өмгөөллийн Коллегийн дарга асан Д.Тогтохжаргалын өгсөн ярилцлагаас.....	12
Шигтгээ 2.	МУИС-ийн Хууль зүйн сургуулийн хүндэт доктор Юрген Харбих.....	13
Шигтгээ 3.	Монгол Улсын төрийн шагналт, соёлын гавьяат зүтгэлтэн, ардын уран зохиолч Бавуугийн Лхагвасүрэн.....	13
Шигтгээ 4.	Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, Гавьяат хуульч, доктор, профессор Бяраагийн Чимид.....	14

УДИРТГАЛ

Дэлхийн хөгжлийн чиг хандлага болсон техник, технологийн хурдтай зэрэгцэн цахим орчинд хүний эрхийн болон эрх зүйн мэдээлэл нэмэгдэж, иргэдийн мэдлэг тэлэхийн хэрээр хуульчдаас, тэр дундаа тангараг өргөсөн өмгөөлөгчдөөс өргөн хүрээний мэдлэг боловсрол, өндөр ёс зүйг шаардах болжээ.

Иргэд, үйлчлүүлэгчийн зүгээс мэргэжлийнхээ хүрээнд хараат бус, бие даасан, шударга, зөв байх эрхэм чанар, үнэт зүйлийг төлөвшүүлсэн, өндөр хариуцлага, ёс зүйтэй байхыг тангараг өргөсөн хуульч, өмгөөлөгчөөс шаардах нь тэдэнд итгэх итгэлийн баталгаа болдог. Нөгөө талаас энэ нь шударга нийгмийг бүтээх, хүний эрхийг хангах баталгаа болдог төдийгүй “Шударга шүүх, сайн хуулийг бий болгох гол хүчин зүйл нь сайн хуульч”¹ хэмээн үздэгтэй холбоотой.

Хууль зүйн салбар болон хуульчдын төлөөлөл болсон “өмгөөлөгч” гэх нэр хүндтэй мэргэжилд хариуцлагагүй хандах, үйлчлүүлэгчээ хууран мэхлэх, худал амлах, ажил үйлчилгээгээ эрхлээгүй байж их хэмжээний төлбөр нэхэх, үйлчлүүлэгчтэйгээ холбогдохгүй байх, үйлчлүүлэгчээ дарамтлах, өөрийн болон эсрэг талын үйлчлүүлэгчийг үг, үйлдлээр доромжлох, шүүх хурал үндэслэлгүйгээр хойшлуулах, өмгөөлөгч мөн эсэх нь ойлгомжгүй байх (*Эрцүгийн хэрэгт өмгөөлөгч байхыг шаарддаг хэдий ч иргэний хэрэгт итгэмжлэлээр хууль зүйн туслалцаа цэцүлж болдог тул заавал өмгөөлөгч байх, өмгөөлөгчийн үнэмлэх, тамга тэмдэгтэй байхыг шаарддаггүй. Иймд эрхээ түдгэлзүцүлсэн эсвэл хүчингүй болгосон эсвэл огт өмгөөлөгчийн эрх аваагүй хуульчид ажилладаг.*) зэргээр иргэдийг төөрөгдүүлэх, бухимдуулах нь өнөөгийн нийгмийн тулгамдсан асуудал болжээ.

Иймд уг судалгааны зорилго өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагын механизм, практикт тулгамдсан асуудлыг судлан, шийдвэрлэх арга замыг тодорхойлоход оршино. Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүллээ. Үүнд:

¹ Б.Чимид, “Төр нам эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудлууд”, 2008, 53 дахь тал.

- Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн хариуцлагын механизмыг судлах;
- Гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалтаар өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн хариуцлагын механизмыг харьцуулан судлах;
- Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн хариуцлагын механизм, практикт тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд холбогдох эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийснээр шийдвэрлэх арга замыг тодорхойлоход чиглэнэ.

Энэхүү ажлыг хийж гүйцэтгэхэд ажиглах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, түүхчлэн судлах ба бусад улсад (АНУ, ХБНГУ, Япон улс) өмгөөлөгчийн ёс зүйн зөрчилд хүлээлгэж буй хариуцлагын механизмыг харьцуулан, Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбооны мэргэжлийн хариуцлагын хорооноос өмгөөлөгчид хариуцлага хүлээлгэсэн статистик тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийн, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль (2012 он), Өмгөөллийн тухай хууль (2019 он), Монголын Өмгөөлөгчдийн холбооны Их хурал болон Удирдах зөвлөлөөс баталсан Мэргэжлийн хариуцлагын хороонд хамаарах дүрэм, журам, эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэртэй танилцах зэргээр баримт бичгийн судалгаа хийж, Өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч, удирдах зөвлөлийн зарим гишүүд зэрэг албан тушаалтантай ганцаарчилсан, Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэсэн мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүдтэй фокус бүлгийн ярилцлага, өмгөөлөгчийн ёс зүйн талаар иргэдээс онлайн санал асуулга авч судалгааны чанарыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллалаа.

Судалгааны ажлыг шинжлэх ухааны хавсарга судалгаа болох бодлого, практикт чиглэсэн байдлаар гүйцэтгэн, судалгааны дүгнэлтийг зөвхөн тухайн судалгаагаар тогтоогдсон бодит байдалд үндэслэсэн болно. Мэргэжлийн хариуцлагын хорооноос өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхэд баримтлах хууль, дүрэм, журамд зааснаар мэргэжлийн ёс зүйн зөрчил гарсан тохиолдолд хариуцлагын механизм байгаа эсэх, эрх зүйн акт хоорондын уялдаа холбоо хангагдсан эсэхийг

тодорхойлсны үндсэн дээр өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйгүй байдал, шийдвэрлэж буй маргаантай холбогдуулан тулгамдсан асуудлыг тодорхойлон, судалгааны онол, арга зүйд тулгуурлан шийдвэрлэх арга замыг судлан санал, зөвлөмж боловсрууллаа.

Цаашид энэхүү судалгаа өмгөөлөгч мэргэжлийн ёс зүйг сахиж ажилладаг эсэх, өмгөөлөгчийн ёс зүйн зөрчил нийгэмд нуугдмал хэлбэрт оршиж байгаа эсэх, өмгөөлөх эрхгүй этгээд итгэмжлэгдсэн төлөөлөгч нэрээр иргэдэд хууль зүйн зөвлөгөө өгч, ёс зүйн зөрчил гаргахад түүнд хүлээлгэх хариуцлага холбогдох эрх зүйн актад тусгалаа олсон эсэх, өмгөөлөгчийн нэр хүнд, хариуцлагын асуудлыг нэмэгдүүлэхэд анхаарч байгаа эсэх зэргээр олон асуудлыг шийдвэрлэхэд ач холбогдолтой гэж үзсэн болно.

Мөн судалгааны зорилтын хүрээнд дэвшүүлсэн судалгааны үр дүн, дүгнэлтэд үндэслэн холбогдох эрх зүйн актад өөрчлөлт оруулах санал, зөвлөмж боловсруулах, нийгэд сурталчлах замаар өмгөөлөгчийн нийгэмд эзлэх байр суурь, мэргэжлийн ёс зүй, мэргэжлийн нэр хүнд дээшлэх, шүүх эрх мэдлийн хүрээнд хийх эрх зүйн шинэтгэлийн чухал хэсэг болох хүний эрхийг хангахад өчүүхэн төдий тус нэмэр болох боломжтой гэж үзэж байна.

НЭГ. ӨМГӨӨЛӨГЧИЙН МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙН ХАРИУЦЛАГЫН МЕХАНИЗМ

1.1. ӨМГӨӨЛӨГЧИЙН МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлгийн Арван зургаадугаар зүйлийн 14-т “эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл... өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах...” үндсэн эрхтэй тухай заасан бол Арван есдүгээр зүйлийн 1-д “Төрөөс ... хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж, Дөрөвдүгээр бүлгийн Тавин тавдугаар зүйлийн 1-д “Шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх эрхтэй.”, 2-т “Шүүгдэгчид энэ эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ.” гэж өмгөөллийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх үндсэн эрхийг хуульчилсан байна.

Харин өмгөөлөгчийн талаар Монгол хэлний их тайлбар тольд² “Өмгөөлөгч” гэдэг нь 1/ Гэмт хэрэг үйлдсэн хүнд хууль зүйг баримтлан шүүмжилж түүнд оноох ялыг хөнгөтгөх арга замыг эрэлхийлэн хэлцэгч хүн, 2/ хамгаалагч этгээд гэж тайлбарласан бол Англи, Орос, Герман-Монгол олон улсын эрх зүйн тольд³ “Advocate-адвокат, защитник, советник-(schott.) Advokat, Verteidiger, (amer.) Rechtsbeistand, Verfechter-өмгөөлөгч, хамгаалагч, зөвлөх” гэсэн бол Эрх зүйн толь бичигт⁴ “Хувь хүн, хуулийн этгээдэд (зөвлөгөө өгөх, шүүхэд тэдгээрийн ашиг сонирхлыг төлөөлөх) эрх зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлдэг, яллагдагчийг өмгөөлдөг хуульчийг өмгөөлөгч” гэж тайлбарлажээ.

Өмгөөллийн тухай (2002 он) хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Хуульч сонгон шалгаруулах тухай хуульд заасан сонгон

² Монгол хэлний их тайлбар толь, 2015. Монгол хэлний их тайлбар толь (<https://mongoltoli.mn/>) [сүүлд нэвтэрсэн 2022.09.19]

³ Ж.Амарсанаа, Англи, Орос, Герман-Монгол олон улсын эрх зүйн толь, 2004, 40 дэх тал.

⁴ С.Нарангэрэл, Эрх зүйн толь бичиг, 2008, 348 дахь тал.

шалгаруулалтад тэнцэж, гэрчилгээ авсан этгээд, ял шийтгэлгүй, тогтоосон журмын дагуу мэргэшлийн шалгаруулалтад орж, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан иргэнийг өмгөөлөгч гэнэ” гэж анх удаа өмгөөлөгчийн талаар тодорхойлолтыг хуульчилжээ. Тус хуулийг 2012 онд хүчингүй болгож, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д “хуульч” гэж хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй этгээдийг ойлгохоор өөрчлөн найруулсан.

Өмгөөллийн тухай (2019 он) хуулийн 8 дугаар зүйлийн 8.8-д “Хуульч өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг авахдаа «Өмгөөлөгч би Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, өмгөөлөгчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж ажиллахаа батлан тангараглая. Миний бие өргөсөн тангаргаасаа няцваас хуулийн хариуцлага хүлээнэ.» гэж тангараг өргөдөг. Харин “Өмгөөлөгчийн ёс зүйн хэм хэмжээ”-ний талаар 31 дүгээр зүйлийн 31.2-т “Ёс зүйн дүрэм нь өмгөөллийн үйл ажиллагаанд заавал дагаж мөрдвөл зохих ёс зүйн хэм хэмжээ, өмгөөлөгчид хариуцлага хүлээлгэх үндэслэл, журмыг агуулсан байна.” гэж заажээ.

Ийнхүү өмгөөлөгчийн талаар албан ёсны тайлбар, тодорхойлолтоос үзвэл өмгөөлөгч гэж иргэдийг аливаа ёс зүй, ёс суртахуунгүй үйлдлээс хуулийн дагуу мэргэжлийн туслалцаа үзүүлэн, өмгөөлөн хамгаалагч байх төдийгүй, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, хууль дээдэлсэн, шударга ёсны төлөө төрийн өмнө онцгой үүрэг хүлээсэн, ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллахаа төрийн сүлд болон далбаандаа хүндэтгэл үзүүлэн батлан тангарагласан хүнийг ойлгох юм.

Мөн орчин үеийн эрдэмтэн, судлаачийн үзсэнээр “Өмгөөлөгч нь зөвхөн нэг орны төдийгүй, дэлхий дахинд түгээмэл ач холбогдолтой, өндөр нэр хүндтэй, хуульч мэргэжлийн нэгэн тулгуур багана нь болдог онцгой мэргэжил мөн”⁵ бөгөөд “Өмгөөлөгч бол хууль зүйн

⁵ Т.Сэнгэдорж, С.Энхмэнд, С.Энхсаруул, Дэлхийн ба Монголын хуульчид эрх зүй ёс зүй, 2014, 8-9 дэх тал.

мэргэжил анх үүсэхэд буй болсон, эмчтэй ямагт адилтган үздэг, хүмүүнлэг мэргэжлийн нэгэн төрөл мөн”⁶ гэжээ.

Францын хуульч Андре Мари, Жан Жак Дюпен “Улс орон эр цэргүүдээрээ төдийгүй өмгөөлөгчдөөрөө хамгаалагдаж байдаг”⁷ гэсэн нь өмгөөлөгчийн төр засаг, иргэдийн өмнө хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой харуулсан ба “Өмгөөлөгчийн ажил мэргэжил нь хууль зүйн мэргэжлийн асар их ур чадварыг шаарддаг, хүний төлөө чин санаа тавьдаг, үйлчлүүлэгчийнхээ хууль ёсны эрх ашгийн төлөө өөрийгөө ч золиосолдог ажил мэргэжил”⁸ төдийгүй “...хүний итгэл хүндэтгэл хүлээж, хувийн амьдралд нөлөөлөх хууль зүйн болон ёс суртахууны үүрэг хүлээж ажилладаг, бүр хувийн амьдралд нь хутгалдан мэргэжлийн туслалцаа үзүүлдэг”⁹ онцлогтой байна.

Хүн нийгмийн харилцаанд оролцохдоо ёс суртахууны нийтлэг хэм хэмжээг сахидаг. Харин хуульч мэргэжил эзэмшиж өмгөөлөгч болсны хувьд бусадтай харилцахдаа мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг хатуу сахих учиртай.¹⁰ Өмгөөлөгчийн ёс зүйн хэм хэмжээг чандлан баримтлах нь хүний эрхийг хамгаалах, нийгмийн шударга ёсыг тогтоох, өмгөөллийн үйл ажиллагааг үр нөлөөтэй болгох, энэ мэргэжлийн нэр хүндийг дээшлүүлэхэд нэн чухал урьдач нөхцөл болдог.¹¹

Диплом өвөртөлсөн, сонгон шалгаруулалтад тэнцсэн болон тэнцээгүй хууль, эрх зүйн зөвлөгөө туслалцаа үзүүлдэг олон хүмүүс бий. Тэд өмгөөлөгчдийн холбоонд харьяалагдахгүйгээр, өмгөөлөгч гэсэн нэр зүүлгүй бусдад үзүүлж буй туслалцааныхаа хувьд үйлчлүүлэгчдийнхээ өмнө ёс зүй, сахилгын ямар үүрэг хүлээх¹² нь ойлгомжгүй байдаг.

⁶ С.Нарангэрэл, Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо, 2001, 146 дахь тал.

⁷ “Өмгөөлөгч мэргэжил” нийтлэл, <https://advocate.mn/news/119/single/118> [Сүүлд нэвтэрсэн 2022.8.28]

⁸ С.Нарангэрэл, Н.Лүндэндорж, Эрх зүй судлалын удиртгал, 2002, 65-66 дахь тал.

⁹ Д.Тогтохжаргал, Төрийн хүн (намтар, дурсамж), 2011, 187 дахь тал.

¹⁰ Монголын Өмгөөлөгчдийн холбоо, “Өмгөөлөл судлал” I боть, 2011, 181 дэх тал.

¹¹ Монголын Өмгөөлөгчдийн холбоо, “Өмгөөлөл судлал” I боть, 2011, 186 дахь тал.

¹² Монголын Өмгөөлөгчдийн холбоо, “Өмгөөлөл судлал” I боть, 2011, 261 дэх тал.

Гэтэл өмгөөлөл нь хууль тогтоомжоор хүлээн зөвшөөрөгдөж бас түүгээр хязгаарлагдаж байдаг бөгөөд энэ нь өмгөөлөгчийн үг, үйл хөдлөлөөр илрэн гардаг”¹³ ёс зүйтэй байхаа тангарагласан онцгой үр чадвар шаардсан мэргэжил гэдэгтэй холбоотой.

Шигтгээ 1.	1964 онд Монголын өмгөөллийн коллегийн дарга асан Д.Тогтохжаргалын өгсөн ярилцлагаас
<ul style="list-style-type: none">- Ёс зүйтэй өмгөөлөгч, өмгөөлөгчийн ёс зүй гэж нэлээд ярьж байна. Ёс зүйн талаар таны бодлыг сонсмоор байна.- Одоо зарим өмгөөлөгч хүнийг өмгөөллөө л бол, хэдэн төгрөг авлаа л бол ажил нь дуусаж байх шиг. Миний үед өмгөөлөгч үйлчлүүлэгчээ ялтан боллоо ч гэсэн захиа занаагаар харьцдаг, суллагдсан хойно нь ажил албанд нь оруулж өгч тусалдаг, тийм холбоотой байдаг байв. Үйлчлүүлэгч өмгөөлөгчдөө маш их итгэсэн бол орон шоронд орлоо ч гэсэн байнгын холбоо харилцаатай байдаг. “Тийм хүнд ял авах гэж байхад хөнгөлж зөөллөж өгсөн шүү та, “Одоо би алдаагаа яаж засах вэ, та надад туслаач” гэх зэргээр үргэлж харьцдаг тийм холбоо байсан шүү. Үүнийг л ёс зүй гэх болов уу.	

Манай улс 1992 оноос эхлэн ардчилсан, хүний эрх, хууль ёсыг дээдэлсэн эрх зүйт төрийг төлөвшүүлэхээр Монгол Улсын Үндсэн хуулиараа зохицуулан, иргэн бүр үнэ цэнтэй амьдрах боломжийг олгосон. Гэсэн хэдий ч нийгмийн ёс суртахууны үзэл баримтлал, нийгмийн сэтгэл зүй, хүний хөгжлийн философид суурилсан онол, арга зүйн судалгаа, эрдэм шинжилгээний ажил ховордсоноос ажилгүйдэл, ядуурал, мөнгөний болон хувийн эрх ашгийн төлөө юу ч хийхээс буцахгүй нийгмийн нэг бүл давхарга бий болжээ. Ёс зүй, ёс суртахууны үлгэр дуурайлал болсон шударга ёсыг сахиулагчид байх учиртай шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгчдээс зарим хуульч, өмгөөлөгч энэхүү давхаргыг бүрдүүлж байгааг үгүйсгэх аргагүй юм.

¹³ З.Сүхбаатар, Хуульчдын холбооны үйл ажиллагаан дахь өмгөөлөгчийн оролцоо, Хуульч сэтгүүл, 2014 оны 12 дугаар сар, № 01 (01), 28 дахь тал.

Шигтгээ 2.

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Хүндэт доктор
Юрген Харбих

“Үндсэн хуульдаа бидний тунхагласан хүний эрх, хуулийн өмнө хүн бүр тэгш байх явдал, ялангуяа хүйсийн тэгш эрх, шашин шүтэх эрх чөлөө, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, шинжлэх ухааны эрх чөлөө, ардчилсан сонгох сонгогдох эрх, эрх мэдлийн хуваарилалт, хуульд захирагдах ёс, дур зоргоор авирлахыг хориглох, эрх зүйг шүүх эрх мэдлээр хамгаалах ёс, шүүгчийн хараат бус байдал, эцэст нь дурдалгүй өнгөрч үл болох зүйл бол эрх зүйт төрийн титэм болсон Үндсэн хуулийн шүүх эрх мэдэл юм. Энэ бүгд үнэ цэнтэй зүйлс гэдэг нь маргаангүй” хэмээн өнөөгийн нийгмийн үнэт зүйлийг тодорхойлсон.

Харин эдгээр үнэт зүйлсийн төлөө бүх хүчин чармайлтаа дайчлан ажиллах нь хүн бүрийн үүрэг хариуцлага юм гэдгийг тэрээр онцолсон төдийгүй төрийн эрх мэдлийн гурван салаанд хамаарах хуульчдын (*шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатч, хуульчийн сонгон шалгаруулах шалгалтад тэнцсэн, тангараг өргөсөн хуульч зэрэг*) гүйцэтгэх үүрэг их байдгийг тайлбарлажээ. Хуульч хүнд хүлээлгэх үүрэг хариуцлага өндөр байх, хүн чанар, амин чанар, мөн чанарыг илүүтэй суралцсан байхыг шаарддаг төдийгүй төрийн ажилд хамгийн ойр мэргэжилд тооцдог байна.

Шигтгээ 3.

Монгол Улсын Төрийн шагналт, Соёлын гавьяат
зүтгэлтэн, Ардын уран зохиолч Бавуугийн
Лхагвасүрэн

“Хуульч хүн гэдэг томилогдсон албан тушаал, тохоогдсон эрх ямба, оноогдсон хувь заяа юм. Хууль бол биеэ даасан шинжлэх ухаан учраас өөрийнхөө бэлтгэл хүчнийг ямагт нэрж гаргаж байдаг. Мөрдөх ёстой хууль нь тэнгэрийнх байдаг учраас хуульчид бол тэнгэрийн томилгоотой хүмүүс гэж би боддог. Тэнгэрт таалагдсан хуульч хүнд таалагдсан хуульч л байж таарна аа даа. Би хувьдаа хүн чанартай, ноён нуруутай хүнийг л хуульч гэнэ.”

Ийнхүү ард түмний төлөөлөл болсон эрхэм “хуульч” хүний талаар тодорхойлсноос үзвэл, хүлээлгэх өндөр хариуцлага, хүн чанар, ноён нуруу байх ёстойг илэрхийлжээ.

Шигтгээ 4.	Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, Гавьяат хуульч, доктор, профессор Бяраагийн Чимид
“Улс төрийн бодлогыг томъёолдог, амьдралд тодруулж хэрэглэх бололцоо олгодог, болохгүй бол дүгнэдэг, тайлбарлаж өгдөг, хэрэглэдэг ийм хүмүүс бол хуульч. Түүнийг нийгмийн харилцааны инженер ч гэж хэлдэг.”	

Харин хуульчдын төлөөлөл болсон эрхэм “хуульч” хүний талаар тодорхойлсноос үзвэл хуулийг амьдралд, иргэдэд ойртуулах, тайлбарлан ойлгуулах нийгмийн харилцааны гол хүчин зүйл “инженер” гэж илэрхийлсэн байна.

Ёс зүй судлаачид 1972 оны Уотергейтийн дуулианыг (Watergate scandal) олон оронд Ёс зүйн хороод байгуулагдах, албан хаагчдын ёс зүйн асуудалд өндөр ач холбогдол өгөх шалтгааныг бий болгосон түүхэн үйл явдалд тооцдог. АНУ-ын ерөнхийлөгч Richard Nixon Вашингтон хотын “Уотергейт” зочид буудал дахь Ардчилсан намын төв байранд чагнах төхөөрөмж тавьсан хэргийг нуун дарагдуулж, худал мэдүүлэг өгсөн хэргээр албан тушаалаасаа огцорсон билээ. Энэ хэргийн дараа АНУ-ын Хуульчдын холбоо бүх хуулийн их сургуулиудад ёс зүйн хичээл оруулах шаардлагыг тавьсан бөгөөд 1978 онд Засгийн газрын ёс зүйн хууль (Ethics in Government Act) батлагдсан.¹⁴ Ийнхүү иргэд төрийн байгууллага болон хууль хяналтын байгууллагын албан хаагчид итгэл хүлээлгэн ёс зүйн өндөр шаардлага тавьдаг төдийгүй хэрэв худалдаачин, мэргэжилтэн, инженер, эмч хүн хулгайн хэрэгт оролцлоо гэвэл тухайн хүнээс

¹⁴ Richard Cowell, James Downe, and Karen Morgan, “Managing politics? Ethics regulations and conflicting conceptions of good conduct”, Public administration review, January/February 2014, pages 29-30.

болоод тухайн байгууллагын үйл ажиллагаа бүхэлдээ муудна гэж байхгүй, харин шүүгч, хуульч хүн хулгайн хэрэгт оролцвол “хууль хяналтын байгууллагад бүхэлд нь үл итгэж, албан тушаалаа урвуулан ашигласан гэж сэжиглэх”¹⁵ болдог байна.

Тиймээс хуульч, өмгөөлөгч мэргэжлийг ёс суртахууны өгөгдлөөс ангид авч үзвэл энэ мэргэжил утгаа алдана, хуульч гэсэн нэр зүүж явах нэр хүндээ алдахад хүрдэг байна. “Монголын хуульчдын мэргэжлийн нэр хүнд ямар байх нь тэдний ёс зүйгээс шууд шалтгаална”¹⁶, “Хуульчийн мэргэжлийн гол үнэт зүйл бол хуульчийн ёс зүй байдаг”¹⁷ гэснээс үзвэл ардчилсан, эрх зүйт нийгэмд онцлох үүрэгтэй хуульчид ёс зүйтэй, ёс суртахууны өгөгдлийг өөртөө бий болгон төлөвшсөн байх юм.

Харин хууль зүйн сургалт явуулдаг их, дээд сургуульд хөтөлбөрийн дагуу ёс зүйн хичээл ордог болсон нь авууштай хэдий ч эрх зүйт төрийг төлөвшүүлж буй өнөөгийн нийгэмд 1-2 кр цагийн сургалт төдийлөн хангалттай байж чадахгүй. Учир нь хууль гэдэг бол ёс суртахууныг бэхжүүлэгч, хамгаалагч, тогтоогч, гэмтнийг цээрлүүлдэг, гэмгүйг хамгаалдаг дэлхийн сонгомол хэрэглүүр юм. Үүнийг амьдруулагч нь “хуульч” гэдэг мэргэжлийн хүн. Хуульчид бол хуулийнхаа амин сүнс шиг байх тул ёс суртахуунаа алдвал хууль хэрэгжихгүйд¹⁸ хүрэх тул тангараг өргөсөн ажил албан тушаал ёс зүйг дээд түвшинд баримтлан, ёс зүйн шаардлагад тавих шалгуур, зарчмыг өндөрсгөн, иргэдэд үлгэр дуурайлал үзүүлэн ажиллах, хууль тогтоомжийн биелэлтийг хангах нь чухал юм.

Хуулийн сургуулийг эрх зүйчээр төгсөн 2 жилийн хугацаанд дадлага хийж, хуульчийн шалгалтад орж тэнцсэнээр хуульчийн

¹⁵ Р.Вандангомбо, Ёс зүй, хууль, Монголын Өмгөөлөгчдийн Холбоо “Эрх зүйн мэдлэг” цувралын эхний дугаар, 1997, 21 дахь тал.

¹⁶ Ж.Хунан, “Монголын хуульчийн ёс зүйн онол-практикийн зангилаа асуудалд” сэдэвт илтгэл, Монголын хуульчдын ёс зүй (тулгамдсан асуудал), Эрдэм шинжилгээний бага хурлын өмнөх үг, 2019.

¹⁷ Ж.Эрдэнэбулган, “Монголын хуульчийн ёс зүйн онол-практикийн зангилаа асуудалд” сэдэвт илтгэл, Монголын хуульчдын ёс зүй (тулгамдсан асуудал), Эрдэм шинжилгээний бага хурлын өмнөх үг, 2019.

¹⁸ С.Нарангэрэл, “Хуульчийн мэргэжилдээ үнэнч байх чанар” лекц, 2016.06.20, (794) “Хуульчийн мэргэжилдээ үнэнч байх чанар” - YouTube [сүүлд нэвтэрсэн 2022.09.19]

тангараг өргөн хуульч болдог. Цаашлаад шүүгч, прокурор, нотариатч, өмгөөлөгчийн шалгалт өгч тэнцсэнээр ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж явахад 2 дахь удаагаа төрийн сүлдэндээ мөргөн тангарагладаг. Гэвч зарим хуульчдын зүгээс өргөсөн тангаргаа зөрчих, ёс зүйгүй үйлдэл гаргах нь цахим орчны мэдээллээс харагдаж байна. Иймд ёс зүй, ёс суртахууны ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, дагаж мөрдөх дүрэм журмаа сайжруулах хэрэгцээ шаардлага байх тул ёс зүй, ёс суртахууны ойлголтын талаар товч авч үзье.

Хувь хүн-иргэн, нийгмийн нийтлэг, бүлгүүдийн зан үйлдэл болон бүхэлдээ нийгмийн харилцан үйлчлэл, хамаарал, нийгмийн холбооны явцад үүсэн бий болж байгаа нийгмийн харилцааг зохицуулах үүргээ биелүүлэх явцдаа ёс суртахуун нийгмийн институци болж бүрэлдэж төлөвших учиртай.¹⁹

Ёс суртахууны хэм хэмжээг бүхэлд нь хуулиар тогтоох боломжгүй, өөрөөр хэлбэл, хүний нийгмийн бүх харилцааг хуульчлахгүй, харин хүний жам ёсны эрхийг төрөөс хангахад чиглэсэн байх бөгөөд нийгмийн харилцаанд гарах ёс суртахуунгүй үйлдлийг хязгаарлах нь зөвшөөрсөн хэм хэмжээний нийгмийн учир холбогдлын мөн чанарыг олон нийт ухааран ойлгож, ёс суртахуунтай амьдрах итгэл үнэмшилтэй болох юм. Өөрөөр хэлбэл, ёс зүйн онолын үүднээс авч үзвэл деонтологи буюу үүргийн онол, шударга ёсны онолын хандлагад илүү нийцэх юм.

“Монголчууд үндэсний ёс зүй, ёс суртахууны ариун нандин, үнэт өв уламжлалтай. ...Тэдгээр их өв уламжлалаас энгийн хийгээд иргэний, нийтийн ёс суртахуунд холбогдох багц ухагдахуун, хэм хэмжээнээс цөөн хэсгийг дээжлэн (*хавсралт 1-ээс үзнэ үү*) авч үзвэл монгол үндэсний ёс зүй, ёс суртахууны өгөгдөл, ариун нандин, үнэт өв уламжлал нь хуульчийн ёс зүйд тод томруун илэрч байх ёстой болдог²⁰ байна.

¹⁹ Б.Галиндэв, “Нийгмийн ёс суртахуун институци болох нь” сэдэвт илтгэл, Монгол Улс дахь хуульчдын ёс зүйн тулгамдсан асуудал, Эрдэм шинжилгээний бага хурал, 2019, 77 дахь тал.

²⁰ С.Нарангэрэл, “Монголын хуульчийн ёс зүйн онол-практикийн зангилаа асуудалд” сэдэвт илтгэл, Монголын хуульчдын ёс зүй (тулгамдсан асуудал), Эрдэм шинжилгээний бага хурал, 2019, 21 дэх тал.

Аливаа улсын засаглалын хүч суларсан, эрх баригчид нь авлигад автсан улсын иргэд ёс суртахууны уналт доройтолд орсноор гэмт хэрэг ихсэж байдаг бол эсрэгээрээ засаглал нь тэнцвэртэй, авлига үгүй улсад ёс суртахууны эерэг хандлага давамгайлж гэмт хэрэг буурч байгааг судалгааны үр дүнгүүд харуулсаар байна.

Ийнхүү Монгол Улсын ёс суртахууны талаар зохицуулж ирсэн аргыг XIX, XX, XXI зууны эхэн гэсэн гурван үед хуваан агуулгад дүн шинжилгээ хийсэн²¹ нь нийгэмд голлон оршиж байсан харилцааг хамжлагын (феодалын), нийгэм журмын (социалист), зах зээлийн (шилжилтийн үе) гэж ангилан ялгаж үзсэн байна (*хавсралт 2-оос үзнэ үү*). Өөрөөр хэлбэл, ёс зүйг хүмүүсийн зан суртахууны харилцаа, ёс суртахууныг судалдаг ухаан гэж²² онолын болон норматив ёс зүйн үүднээс авч үзэн олонх мэргэжилтнүүд тодорхойлсоор ирсэн нь Монголын ард түмэн ёс зүй, ёс суртахууны ариун нандин, үнэт өв уламжлалыг өвлүүлж, хөгжүүлж ирснийг харуулж байна.

Нийгмийн хөгжлийн үйл явцыг нарийвчлан ажиглавал тухайн улс үндэстэн өөрсдийн соёлд нийцсэн ёс суртахууныг бий болгох ба тэр нь нийгмийн шинж байдал, хөгжлийн тусгал болж, нийгмийн харилцаагаар өргөжин тэлж, улмаар эрх зүйн тогтолцооны үндэс болдог байна. Тухайн улс үндэстэн өөрийн хөгжлийн төвшнөөс үүдсэн хэрэгцээ шаардлагад тохирсон олон талт харилцааг зохицуулах хууль, дүрэм, журмыг боловсруулан хяналтыг тодорхойлж түүнийгээ баримтлах, хэвшүүлэх, дадал болгох арга хэлбэрийг сонгон хэрэглэж буйг ёс зүйгээс үүдэлтэй механизм үйлчилж байна гэж үзэж болох юм.

²¹ Г.Жаргал, Н.Сэлэнгэ, Ёс суртахууны зохицуулалтын агуулга, аргын өөрчлөлт, “Хууль дээдлэх ёс” Цуврал 1 (76), 2020, 45 дахь тал.

²² Р.Вандангомбо, Ёс зүй, хууль, Монголын Өмгөөлөгчдийн Холбоо “Эрх зүйн мэдлэг” цувралын эхний дугаар, 1997, 21 дахь тал.

1.2. ӨМГӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙН ХАРИУЦЛАГА

Хүний эрх, эрх чөлөө, түүнийг хамгаалах асуудал бол Монгол Улсын Үндсэн хуулийн тулгуур үзэл баримтлал, зарчмын нэг бөгөөд үүний гол бүрэлдэхүүн хэсэг нь иргэний хууль зүйн туслалцаа авах, өмгөөлүүлэх эрхтэй холбогдох харилцаа юм. Хүний жам ёсны эрх буюу “хүний эрх нь төрөлхөөс заяасан бөгөөд хамгийн эгэл утгаараа хүнд өөрт нь байдаг нийгмийн дотор заавал эдлэх боломж”²³ бөгөөд бусдын халдашгүй байх, тэгш эрхтэй байх зэрэг үндсэн эрхээр хязгаарлагдаж нийгмийн харилцаанд оролцогч иргэний хувьд үүрэг хүлээж, эс биелүүлбэл хариуцлага үүсэх үр дагавартай.

Үндсэн хуулиар олгогдсон хүний үндсэн эрхийг хангах буюу “хууль ёсоор олгогдсон өмгөөлүүлэх эрхийг хэрэгжүүлэх үүрэг бүхий өмгөөлөгчид нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг тууштай хамгаалж, тэдэнд шаардлагатай хууль зүйн туслалцааг үзүүлээд зогсохгүй, холбогдсон хэргийг тал бүрээс нь бүрэн дүүрэн бодитой шинжлэн судалж, түүнийг хууль зүйн үндэстэй, үнэн зөв мөрдөн шалгаж, шийдвэрлэхэд туслах бөгөөд өөрийн үйл ажиллагаандаа зөвхөн хууль зүй, ёс суртахуунд нийцсэн аргуудыг ашиглах ёстой.”²⁴

Өмгөөлөгч нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид хохиролтой үйл ажиллагааг явуулах буюу тэдний холбогдсон хэргийг илчлэх, гэм бурууг нь хүндрүүлэх, нотолгоог илрүүлэн гаргах ёсгүй.²⁵ Хэргийг илчлэх, гэм бурууг олж тогтоох нотлох баримтуудыг цуглуулах эрх хэмжээ, илрүүлэх арга хэрэгсэл хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарт хуулиар олгогдсон байх тул өмгөөлөгч зөвхөн өмгөөлөх үүргийг хүлээдэг.

Үндсэн хуулийн дараа үйлчлэх Иргэний хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулиуд болон процессын хуулиуд болох Үндсэн

²³ Б.Чимид, Үндсэн хуулийн мэдлэг, 2008, 89 дэх тал.

²⁴ Я.Нямжав, Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох нь, Монголын Өмгөөлөгчдийн Холбоо “Эрх зүйн мэдлэг” цувралын эхний дугаар, 1997, 21 дэх тал.

²⁵ Мөн тэнд.

хуулийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд хүний эрхийг хангах, хамгаалахад чиглэсэн гол зохицуулалтыг хуульчилсан бөгөөд процессын хуульд өмгөөлөх, хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг нарийвчлан зохицуулжээ.

Харин иргэдийн хууль зүйн туслалцаа авах, өөрөө өөрийгөө өмгөөлөх эрхийг хангах, өмгөөлөгчдийн мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагын эрх зүйн байдлыг тогтоон бэхжүүлэх, өмгөөллийн үйл ажиллагаа, өмгөөлөгчийн эрх, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор 2019 онд Өмгөөллийн тухай²⁶ хуулийг шинэчлэн баталсан байна.

Өмгөөллийн тухай хуульд өмгөөлөгчийн үйл ажиллагаандаа баримтлах зарчим, үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, шийдвэрийг хүндэтгэн, үйлчлүүлэгч болон бусад этгээдтэй харилцахдаа хүндэтгэлтэй хандаж, Ёс зүйн дүрмийг баримтлан ажиллахыг удирдлага болгох тухай заажээ. Мөн уг хуульд өмгөөлөгч өмгөөллийн үйл ажиллагаанд заавал дагаж мөрдвөл зохих ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд түүнд хариуцлага хүлээлгэх үндэслэл, журмыг тогтоосон байна.

Өмгөөллийн тухай (2019 он) хууль хэрэгжиж эхлэхээс өмнө мэргэжлийн алдаа гаргасан өмгөөлөгч нь ёс зүй, ёс суртахуун, ажил хэргийн шинжээрээ тэнцэхгүй болсон, хууль тогтоомж, дүрэм, журмаа зөрчсөн, гэмт хэрэг зөрчил үйлдсэн нь тогтоогдсон зэрэг ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллаагүй бол шалган тогтоож, эрхийг хасах, чөлөөлөх, зайлуулах гэх мэт үе үеийн өмгөөллийн байгууллага сахилгын арга хэмжээ авч хариуцлага хүлээлгэж ирсэн зохицуулалтыг өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох зорилгоор хураангуйлан дараах байдлаар авч үзлээ.

1. *Шүүн таслах тухай олонд тусламж үзүүлэх бүлгэмийн дүрэм* (1928 он)-ийн Дөрөвдүгээр бүлгийн 21-д “Тус бүлгэмийн дүрмийг зөрчиж сахилгаас гажуу явж бүлгэмийн нэрийг гутаах гишүүдийг

²⁶ Өмгөөллийн тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=14859>

- даруй хөөн зайлуулмой.”, 22-т “Бүлгэмийн гишүүдээс хөөн гаргах явдлыг түр цагийн товчооны эрхлэгчдийн бүгд хурлаар хянан гүйцэтгэмой” гэж зохицуулсан нь сахилга хариуцлагыг оногдуулах хэлбэрийг зааж өгсөн байна.
2. *Шүүх яамны дэргэд өмгөөлөгчдийг зохион байгуулах тухай* (1934 он) Сайд нарын зөвлөлийн 5 дугаар тогтоолоор өмгөөлөгчдийн дүрмийг баталсан нь Шүүх яамнаас өмгөөлөгчийг 1/ шүүн таслах газраас ял шийтгүүлсэн бол, 2/ өмгөөлөгчийн нэр хүндийг гутаах буруу явдлуудыг гаргах бол, 3/ шүүх яамнаас өмгөөлөгч нарт тогтоож өгсөн дотоодын дүрэм, журмыг зөрчсөн бол өмгөөлөгчийн коллегиос гаргах шийдвэрийг гаргадаг байжээ.
 3. *БНМАУ-ын Өмгөөлөх байгууллагын дүрмийг батлах тухай* (1952 он) БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 253 дугаар тогтоолд өмгөөлөгчдийн коллегоос хөөх явдлыг өмгөөлөгчдийн коллегийн тэргүүлэгчид гүйцэтгэх бөгөөд 1/гэмт хэрэг үйлдэж шүүхийн тогтоолоор шийтгэгдсэн, 2/өмгөөлөгчдийн алдар хүндийг гутаах явдлыг гаргасан, 3/өмгөөлөгчдийн коллегийн дотоод дүрмийг зөрчсөн тохиолдолд гишүүнээр авахаас татгалзсан буюу коллегоос хөөсөн тухай гомдлыг Шүүх яамны сайдад гаргаж болох бөгөөд Шүүх яамны сайдын шийдвэр эцсийн шийдвэр байх тухай заасан байна. Мөн Өмгөөлөгчдийн коллегийн гишүүд өөрсдийн үүргийг үнэнч бусаар биелүүлсэн, хөлсний хэмжээг зөрчсөн зэрэг бусад буруутай хэргийг гаргасан байвал өмгөөлөгчдийн коллегийн тэргүүлэгчдээс тэдэнд дор дурдсан сахилга журмын арга хэмжээнүүдийг авна. 1/урьдчилан сануулах, 2/донгодох, 3/ коллегоос хөөхийг сануулж хатуу донгодох, 4/ өмгөөлөгчдийн коллегийн бүрэлдэхүүнээс хөөн зайлуулах сахилга журмын арга хэмжээ авсан тухайн гомдлыг Шүүх яамны сайдад гаргаж болдог байв.
 4. *Өмгөөлөх байгууллагын дүрэм зааврыг батлах тухай* (1965 он) БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 243 дугаар тогтоолын хоёр дахь хэсгийн 12-д улсын өмгөөлөх коллегийн гишүүнээс хөөхдөө 1/ өмгөөлөгчийн үүрэгт ажилд тэнцэхгүй байгаа нь илэрвэл, 2/ улсын өмгөөлөх коллегийн дотоод дүрмийг удаа дараа зөрчих,

албан үүргээ үнэнч шударгаар биелүүлэхгүй байвал, 3/ өмгөөлөх хөлсийг тогтоосон журмаас гадуур авбал, 4/ гэмт хэрэг өдүүлбэл хөөх асуудлыг өмгөөллийн коллегийн тэргүүлэгчид шийдвэрлэдэг байжээ.

5. *Монголын Өмгөөлөгчдийн коллегийн дүрэм* (1978 он)-ийн Хоёрдугаар бүлгийн 12 дугаар зүйлд таван үндэслэлээр коллегийн гишүүнээс хөөх тухай зохицуулсан байна. Үүнд: 1/ Өмгөөлөгчийн үүрэгт ажилд тэнцэхгүй байвал, 2/Өмгөөллийн коллегийн дүрмийг ноцтой зөрчсөн, өөрийн үүргийг үнэнч шударгаар биелүүлээгүй бол, 3/Өмгөөлөгч нь өөрийн тогтоосон журмаас гадуур шан хөлс авсан байвал, 4/Өмгөөлөгчийн нэр алдрыг гутаасан зөрчил гаргавал, 5/Гэмт хэрэг үйлдвэл коллегийн гишүүнээс хөөх асуудлыг коллегийн тэргүүлэгчид шийдвэрлэх тухай заажээ. Мөн Долоодугаар бүлгийн 39-42 дугаар зүйлд өмгөөлөгчид сахилгын арга хэмжээ авах тухай зохицуулжээ. Ингэхдээ өмгөөллийн коллегийн дүрэм зөрчсөн, үүрэгт ажилдаа шударга бус хайнга хандсан буюу өмгөөлөгчийн нэр алдарт харш бусад зөрчил, дутагдал гаргасан гишүүнд өмгөөлөгчдийн коллегийн тэргүүлэгчдээс сануулах, донгодох, хатуу донгодох, хууль тогтоомжид заасан хугацаагаар бага цалинтай ажилд шилжүүлэх буюу албан тушаал бууруулах, гишүүнээс хөөх гэсэн сахилгын арга хэмжээ авах, сахилгын арга хэмжээ авахтай холбоотой бусад зохицуулалтыг зааж өгчээ.
6. *Монголын Өмгөөлөх байгууллагын тухай БНМАУ-ын хууль* (1986 он)-ийн Долоодугаар бүлгийн 27-30 дугаар зүйлд өмгөөлөгчид сахилгын хариуцлага хүлээлгэх тухай зохицуулсан байна. Ингэхдээ өмгөөллийн үйл ажиллагааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн бусад актын шаардлагыг зөрчсөн өмгөөлөгчид 1/ сануулах, 2/ донгодох, 3/ хатуу донгодох, 4/ өмгөөлөгчдийн коллегийн гишүүнээс хөөх сахилгын хариуцлагыг өмгөөлөгчдийн коллегийн тэргүүлэгчид оногдуулах бол үүнээс гадна хууль зүйн зөвлөгөө өгөх газрын эрхлэгч 1, 2, 3 хэсгийг оногдуулах эрх хэмжээг хуульчилж өгсөн байна.

7. *Өмгөөллийн тухай Монгол Улсын хууль* (1994 он)-ийн Дөрөвдүгээр бүлгийн 18 дугаар зүйлд Өмгөөлөгчийн хариуцлагын талаар хуульчилсан бөгөөд өмгөөлөгчийн хариуцлагагүй ажиллагааны улмаас хууль зүйн туслалцаа авагчид эд хөрөнгийн хохирол учирсан бол уул хохирлыг нөхөн төлүүлэх, гэрээнд заасан туслалцаа үзүүлээгүй бол хөлсийг буцааж төлөх тухай зохицуулсан. Мөн хууль тогтоомж, өмгөөлөгчийн болон хуульчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн өмгөөлөгчид 1/ сануулах, 2/ өмгөөлөл хийх эрхийг нь хасах тухай урьдчилан сануулах, 3/ өмгөөлөл хийх эрхийг хасах сахилгын шийтгэлийг сахилгын зөвлөлийн шийдвэрээр оногдуулах бөгөөд сахилгын шийтгэл ногдуулах журам, сахилгын зөвлөлийн дүрмийг Монголын Өмгөөлөгчдийн холбооны саналыг үндэслэх Хууль зүйн сайд батлах тухай зохицуулжээ.
8. *Өмгөөллийн тухай Монгол Улсын хууль* (2002 он)-ийн Хоёрдугаар бүлгийн 7 дугаар зүйлийн 7.2.5-д “Өмгөөлөгчийн ёс зүйн дүрмийг батлах” тухай зохицуулсан бол 8 дугаар зүйлд Сахилгын хороо байх тухай зохицуулж өгсөн бөгөөд өмгөөлөгчийн сахилга, ёс зүйн байдалд дүгнэлт өгөх, сахилгын шийтгэл ногдуулах эрх бүхий сахилгын хороо 5 гишүүний бүрэлдэхүүнтэй Холбооны дэргэд ажиллах талаар зааж өгсөн. Хуулийн 23 дугаар зүйлд хариуцлагын талаар зохицуулсан нь 1/ сануулах, 2/ тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах тухай асуудлыг Сахилгын хорооны шийдвэрийг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн шийдвэрлэхээр зохицуулсан байна.
9. *Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль* (2012 он) Дөрөвдүгээр бүлэгт Хуульчийн эрх, үүрэг, хариуцлагыг зааж, 29 дүгээр зүйлд “Мэргэжлийн хариуцлагын хороо ёс зүйн болон нөлөөллийн сургалтад албадан суулгах нэмэгдэл шийтгэлийг ногдуулж болох бөгөөд уг сургалтын зардлыг шийтгэл хүлээгч этгээд өөрөө хариуцах бөгөөд хууль тогтоомж, мэргэжлийн дүрмийг зөрчсөн хуульчид 1/ хаалттай болон нээлтэй сануулах, 2/ шүүхэд төлөөлөх эрхийг хугацаатай, хугацаагүй түдгэлзүүлэх, 3/ хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг

хугацаатай, хугацаагүй түдгэлзүүлэх, 4/ хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хугацаатай, хугацаагүй хүчингүй болгох хариуцлага хүлээлгэх талаар хуульчилсан байна. Мөн 54 дүгээр зүйлд Хуульчийн мэргэжлийн дүрэм, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах, Хуульчийн мэргэжлийн дүрмийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх болон хуульчийн ёс зүйн сургалтыг зохион байгуулах, сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүйг боловсруулах, сургалтын үр дүнг тодорхойлох, хуульчийн ёс зүйн асуудлаар судалгаа хийх зэрэг ажлыг Хуульчдын холбооны Хуульчийн мэргэжлийн дүрэм, ёс зүйн асуудал эрхэлсэн хороо (цаашид “Ёс зүйн хороо” гэх) зохион байгуулахаар зохицуулжээ.

Өмгөөлөгчид ёс зүйн хариуцлага хүлээлгэж байсан түүхэн замналаас харахад ёс зүйн алдаа гаргасан өмгөөлөгчийн асуудлыг тодорхой бүтэц шийдвэрлэж ирсэн бөгөөд цаг үеийн нөхцөл шаардлагад нийцүүлэн гишүүнчлэлийг хүчингүй болгохоос гадна сануулах, түдгэлзүүлэх зэрэг хариуцлагын хэлбэр нэмж оруулсан байна. 1986 оноос эхлэн өмгөөллийн үйл ажиллагааг хуулиар зохицуулж эхэлсэн бөгөөд ёс зүй, ёс суртахуун, үйл ажиллагаанаас гарсан зөрчилд сахилгын арга хэмжээ авах, хариуцлага оногдуулахад баримтлах дүрэм, журмыг батлах талаар зохицуулсан төдийгүй хариуцлага оногдуулах хараат бус, бие даасан субъектийг тодорхой зааж, өмгөөлөх байгууллагын дэргэд сахилгын зөвлөл, сахилгын хороо, мэргэжлийн хариуцлагын хороо зэрэг бие даасан бүтэц ажиллаж эхэлсэн байна.

Харин өмгөөллийн үйл ажиллагааг хуулиар зохицуулахаас өмнө дүрмээр зохицуулж байсан бөгөөд өмгөөлөх коллеги нь Шүүх яамны дэргэд ажиллах ба Шүүх яам нэгтгэн удирдаж, коллегийн тэргүүлэгчид хариуцлагыг хүлээлгэдэг байжээ. Үүнээс харахад 2012 он хүртэл ёс зүйн болон мэргэжлийн алдаа дутагдал гаргасан өмгөөлөгчид хариуцлага хүлээлгэх асуудлыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай шууд болон шууд бус хамааралтай субъект шийдвэрлэж байсан бол 2012 онд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар Мэргэжлийн хариуцлагын

хороо байгуулагдаж, хуульч, өмгөөлөгчид ёс зүйн хариуцлага хүлээлгэх механизмыг бүрдүүлсэн байна. 2019 оны Өмгөөллийн тухай хуулиар өмгөөлөгчид хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан бол Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулиар хариуцлага хүлээлгэх тогтолцоог бүхэлд нь хүчингүй болгосон. Шүүгч, прокурор, нотариат, өмгөөлөгчийн үйл ажиллагаанд тус бүрийн хуулиар хариуцлага хүлээлгэх тогтолцоо бүрдсэн хэдий ч хуулиар олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд хууль зүйн туслалцаа үзүүлж буй хуульч нар болон эрх зүйч нарт ямар хариуцлага хүлээлгэх нь тодорхойгүй байдгаас иргэд хохирох явдал ихсэж, хууль зүйн салбарын албан хаагчдад итгэх итгэл буурсаар байгааг анхаарах цаг болжээ.

Иймд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулиар үйл ажиллагаа явуулж буй Хуульчдын холбоо нь төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэх байгууллага болохын хувьд иргэдийн эрхийг хангах үүднээс шүүх, прокурор, өмгөөллийн тухай хуулийн дагуу байгуулагдсан ёс зүйн хорооны үйл ажиллагаанд хараат бусаар хөндлөнгийн хяналт тавих, эрх зүйч болон хуульчдын ёс зүйн асуудлаарх гомдлыг хүлээн авч нээлттэй байдлаар өргөдөл гомдлыг шийдвэрлэдэг хариуцлагын тогтолцоог бий болгох, их дээд сургууль, эрх зүйч, хуульчдын сургалтын агуулгад ёс зүйн хичээлийг онол, практик талаас сайжруулах шаардлагатай байна.

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ӨМГӨӨЛӨГЧИЙН МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙН ХАРИУЦЛАГЫН МЕХАНИЗМ, ПРАКТИКТ ТУЛГАМДСАН ЗАРИМ АСУУДАЛ

2.1. ӨМГӨӨЛЛИЙН МАРГААН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ХОЛБОГДОХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Өмгөөллийн тухай хуулийн Тавдугаар бүлэгт өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн хариуцлага, түүнтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарах зохицуулалтыг хуульчилсан. Тодруулбал, өмгөөллийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэгч нь Өмгөөлөгчдийн холбооны Их хурлаас баталсан²⁷ Ёс зүйн дүрмийг мөрдөнө. Энэхүү Ёс зүйн дүрэм нь өмгөөллийн үйл ажиллагаанд заавал дагаж мөрдвөл зохих ёс зүйн хэм хэмжээ, өмгөөлөгчид хариуцлага хүлээлгэх үндэслэл, журмыг агуулсан байна.²⁸

Өмгөөлөгчдийн холбооны үндсэн чиг үүрэгт өмгөөллийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэгчдээр Ёс зүйн дүрмийг мөрдүүлэхээс²⁹ гадна тэдний мэргэжлийн ёс зүй, мэдлэг, ур чадвар, үзүүлж байгаа хууль зүйн мэргэжлийн туслалцааны чанарыг дээшлүүлэх³⁰ үүрэг мөн адил багтана.

Өмгөөллийн үйл ажиллагаа буюу өмгөөллийн ёс зүйн маргаан шийдвэрлэх ажиллагааны эх сурвалж нь холбогдох хууль тогтоомжоос гадна Өмгөөлөгчдийн холбооны дүрэм, журам болон бусад эрх зүйн актаар зохицуулагдаж байна. Тодруулбал, өмгөөлөгч мэргэжлийн үйл ажиллагаандаа баримтлах Олон улсын гэрээ 24, Монгол Улсын хууль 45, Улсын Их Хурлын тогтоол 3, Засгийн газрын тогтоол 1 үйлчилж байна (*хавсралт 1-ээс үзнэ үү*). Мөн түүнчлэн

²⁷ Өмгөөллийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.6.5 дахь заалт

²⁸ Өмгөөллийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь заалт

²⁹ Өмгөөллийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1 дэх заалт

³⁰ Өмгөөллийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.4 дэх заалт

өмнөх хуулийн хэрэгжилттэй холбоотой Үндсэн хуулийн цэцийн 15 шийдвэр, Улсын дээд шүүхийн 12 тогтоол байгааг судалсан болно. Өмгөөллийн үйл ажиллагаатай холбоотой Өмгөөлөгчдийн холбооны их хурлын тогтоолоор баталсан 5, Өмгөөлөгчдийн холбооны удирдах зөвлөлийн тогтоолоор баталсан 18 дүрэм, журам³¹ байна.

Олон улсын гэрээ: Монгол Улс 1961 онд Нэгдсэн Үндэстний Байгууллага (цаашид “НҮБ” гэх)-д элсэж, 1945 онд батлагдсан НҮБ-ын Дүрэм-ийн бүхий л заалтыг хэлбэрэлтгүй дагаж мөрдөхөө илэрхийлсэн юм. Улмаар Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад нэгдэн орж, соёрхон баталсны зэрэгцээ өмгөөлөл, хууль зүйн туслалцааны талаар заалт орсон буюу иргэдийн эрх, эрх чөлөөг хангах, тэгш эрх шударга ёсыг дэмжсэн олон улсын 20 гаруй гэрээ, конвенцыг дагаж мөрдөх үүрэг хүлээсэн байна.

Хууль тогтоомж: Монгол Улсын Үндсэн хууль болон бусад 40 гаруй хуульд өмгөөлөгч хууль зүйн туслалцаа үзүүлэх эрх хэмжээг хуульчилсан. Эдгээр хуульд ардчилсан нийгмийн үнэт зүйл болсон хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад хуульч, өмгөөлөгчийн гүйцэтгэх үүрэг, хариуцлага хуулийг сахин биелүүлэх, хууль хэрэглэх ур чадвартаа тулгуурлан үйлчлүүлэгчийнхээ эрхийг хамгаалах, энэ үйл явцдаа мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг хатуу сахих талаар өргөсөн тангарагтаа үнэнч байх зэргээр зохицуулж өгсөн. Тухайлбал, Өмгөөлөгчийн үйл ажиллагаа, ёс зүйн хэм хэмжээний талаарх зохицуулалтыг агуулсан гол хуулиас дурдвал Өмгөөллийн тухай³², Хуульчийн эрх зүйн байдлын тухай³³, Хууль зүйн туслалцааны тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай³⁴, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай³⁵, Захиргааны хэрэг шүүхэд хянан

³¹ Монголын Өмгөөлөгчдийн Холбооны дүрэм, журмын эмхэтгэл, 2022

³² Төрийн мэдээлэл сонин, 2019, №49.

³³ Төрийн мэдээлэл сонин, 2012, №11.

³⁴ Төрийн мэдээлэл сонин, 2017, №23.

³⁵ Төрийн мэдээлэл сонин, 2002, №8, хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4.1 дэх заалт

шийдвэрлэх тухай³⁶, Зөрчил шалган шийдвэрлэх тухай³⁷ хууль зэрэг юм. Мөн хүний эрхийг хангах, өмгөөллийн үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр Улсын Их Хурлын 2003 оны 41 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”³⁸-т заасан хэм хэмжээг хатуу баримтлан ажиллах үүргийн талаар зохицуулсан байна.

2.2. ӨМГӨӨЛӨГЧИЙН МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙН ХАРИУЦЛАГЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Өмгөөллийн тухай хуулийн Тавдугаар бүлэгт өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн хариуцлагын талаар зохицуулсан байх бөгөөд хуулийн 31 дүгээр зүйлд 1/ сануулах, 2/ өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг нэгээс гурван жил хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх, 3/ өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хүчингүй болгох арга хэмжээний талаар заажээ. Өмгөөллийн үйл ажиллагаанд заавал дагаж мөрдвөл зохих ёс зүйн хэм хэмжээ буюу өмгөөлөгчид хариуцлага хүлээлгэх үндэслэл, журмыг “Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрэм”³⁹-д нарийвчлан зохицуулахаар, Өмгөөлөгчдийн холбооны Мэргэжлийн хариуцлагын хороо нь хууль болон Ёс зүйн дүрмийг өмгөөлөгч зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх, энэ хууль болон Ёс зүйн дүрмийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх талаар зөвлөмж гаргах чиг үүргийг хэрэгжүүлэхээр зохицуулсан байна.

Мөн хуулийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсэгт “Мэргэжлийн хариуцлагын хорооны бүрэлдэхүүнд шүүгч, прокурор, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, иргэдийн төлөөлөл тус бүр нэг, Өмгөөлөгчдийн Холбооны төлөөлөл долоо

³⁶ Төрийн мэдээлэл сонин, 2016, №9, хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.2 дахь хэсэг

³⁷ Төрийн мэдээлэл сонин, 2017, №24

³⁸ Үндэсний хөтөлбөрийн Хоёрдугаар бүлгийн 2.1.4.3 дахь заалтад “Өмгөөлөгчдийг сонгон шалгаруулах, тэдний ёс зүйн хэм хэмжээг хуульчлан тогтоох, өмгөөлөгчдийн байгууллагын төвлөрлийг задалж орон нутагт бие даасан хэлбэрээр зохион байгуулах, хувийн өмгөөлөгчдийн тоог нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.”

³⁹ <https://drive.google.com/file/d/1HV1kexHSlwDzxpukq7O3XYQy0pZ0Y8JC/view>

байна.” гэж хуульчилсны дагуу Монголын өмгөөлөгчдийн холбооны Мэргэжлийн хариуцлагын хороо 11 гишүүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байгаагаас Монголын өмгөөлөгчдийн холбооны 2020 оны 10 дугаар сарын 3-ны өдөр зохион байгуулагдсан Монголын өмгөөлөгчдийн холбооны Их хурлаар 7 өмгөөлөгч гишүүнийг томилсон бол шүүгчийн төлөөллөөр 1, прокурорын төлөөллөөр 1, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөллөөр 1, иргэний төлөөллөөр 1 иргэн ажиллаж байгаа ба Мэргэжлийн хариуцлагын хорооны анхдугаар хуралдаанаар Мэргэжлийн хариуцлагын хорооны даргаар өмгөөлөгч Дэмбэрэлийн Наранцэцэг сонгогджээ.

Түүнчлэн Монголын өмгөөлөгчдийн холбооны Их хурлын 2020 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан “Монголын өмгөөлөгчдийн холбооны дүрэм”⁴⁰-ийн 59 дүгээр зүйлд Мэргэжлийн хариуцлагын хорооны талаар зохицуулалтыг, Монголын өмгөөлөгчдийн холбооны Их хурлын 2020 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн 08 дугаар тогтоолоор баталсан “Өмгөөлөгчийн ёс зүйн дүрэм”⁴¹-ийн 8 дугаар бүлэгт “Өмгөөлөгчийн ёс зүйн зөрчил, түүнд хүлээлгэх хариуцлага”-ын талаарх асуудлыг, 9 дүгээр бүлэгт Өмгөөлөгчийн мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүн болон ажилтны ёс зүй”-н асуудлыг тус тус тусгасан. Харин Мэргэжлийн хариуцлагын хороо үйл ажиллагаандаа Өмгөөлөгчдийн холбооны Удирдах зөвлөлөөс 2021 оны 3 дугаар сарын 23-ны өдөр баталсан “Мэргэжлийн хариуцлагын хорооны ажиллах журам”⁴², “Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан шийдвэрлэх журам”⁴³-ыг мөрдөж ажилладаг.

Өмгөөлөгчдийн холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны бүтэц, зохион байгуулалтыг авч үзвэл дээр дурдсан 11 гишүүнээс гадна Ажлын албаны дарга 1, хянан шалгагч 2, нарийн бичгийн дарга 1 орон тоотой үйл ажиллагаа явуулдаг бөгөөд өмгөөлөгчийн ёс зүй, мэргэжлийн алдаатай холбоотой өргөдөл, гомдлыг хянан

⁴⁰ <https://www.ama.org.mn/> монголын-өмгөөлөгчдийн-холбооны-дүр/


⁴¹ <https://www.ama.org.mn/> өмгөөлөгчийн-мэргэжлийн-ёс-зүйн-дүрэ/

⁴² <https://drive.google.com/file/d/12-Q1lfl41LoQyc36NUAUtdEt3QUPKooW/view>

⁴³ <https://drive.google.com/file/d/1mRCoGuilf5FgUyf4NEj9EyC7zNtN-xYM/view>

шалгах, шинжлэх үйл ажиллагааг хянан шалгагч давхар хариуцан ажиллаж байгаа нь учир дутагдалтай байна. Тухайлбал, Мэргэжлийн хариуцлагын хорооны тайланд⁴⁴ дурдсанаар өмгөөлөгч хууль болон ёс зүйн дүрмийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх, Өмгөөллийн тухай хууль болон Ёс зүйн дүрмийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх талаар зөвлөмж гаргах чиг үүргийн хүрээнд 2021 онд 213 өргөдөл, гомдлыг хүлээн авснаас 109 гомдолд маргаан үүсгэхээс татгалзаж, 20 гомдолд маргаан үүсгэсэн, 35 гомдолд албан бичгээр хариу өгсөн, 18 гомдол ажиллагаанд байна. Тайлангийн мэдээллээс харахад нийт 213 гомдлын 51 хувьд маргаан үүсгэхээс татгалзсан, 9 хувьд нь маргаан үүсгэх шийдвэр гаргасан бол 31 гомдол буюу 15 хувьд нь ямар арга хэмжээ авсан нь тодорхойгүй байна.

График 1. Гомдол шийдвэрлэсэн байдал (2021 он)




Хэдийгээр Мэргэжлийн хариуцлагын хороо 2021 онд 20 гомдолд маргаан үүсгэсэн гэх боловч хорооны хурлаар хэлэлцээд үүсгэсэн маргааны тоо 29 байна. Үүнээс нэмэлт ажиллагаа хийлгэхээр 5 хэргийг буцааж, 6 хэргийг хэрэгсэхгүй болгожээ. 18 өмгөөлөгчид

⁴⁴ Монголын өмгөөлөгчдийн холбоо, <https://www.ama.org.mn/монголын-өмгөөлөгчдийн-холбооны-2021-оны/>

хариуцлага хүлээлгэснээс 13 өмгөөлөгчид сануулах, 4 өмгөөлөгчийн өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг түдгэлзүүлэх, 1 өмгөөлөгчийн өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хүчингүй болгож шийдвэрлэжээ.

График 2. Маргаан цүсгэсэн хэргийг шийдвэрлэсэн байдал (2021 он)




Өмгөөлөгчдийн холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны 2022 онд хүлээн авсан өргөдөл, гомдол, тэдгээрийн шийдвэрлэлттэй холбоотой тоон үзүүлэлтийг тус хорооны гишүүн, өмгөөлөгчийн Нээлттэй Нийгэм Форум, Хууль зүй, дотоод хэргийн яам, Хууль зүйн туслалцааны төв, Монголын хуульчдын холбоо, Монголын өмгөөлөгчдийн холбооноос хамтран зохион байгуулсан хэлэлцүүлэгт тавьсан илтгэлд дурдсан тоо баримтад үндэслэн дараах байдлаар тогтоох оролдлого хийв.⁴⁵

⁴⁵ Тайлбар: Судалгааны явцад 2022 онд өмгөөлөгчийн ёс зүй, мэргэжлийн хариуцлагатай холбоотой гаргасан өргөдөл, гомдлын тоо, шийдвэрлэлтийн байдалтай танилцах, холбогдох статистик мэдээлэл авах, ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлагыг зохион байгуулахаар хандсан боловч Мэргэжлийн хариуцлагын хорооны даргаас “тус хорооны 2022 оны үйл ажиллагааны тайланг хурлаар хэлэлцүүлээгүй” шалтгаанаар ямарваа нэг мэдээлэл буюу ядаж эхний хагас жилийн тайлантай холбоотой мэдээлэл өгөхөөс эрс татгалзсан хариуг авсан, мөн холбооны 2022 оны үйл ажиллагааны тайлантай танилцах боломжгүй байсан зэрэг нөхцөл байдлаас шалтгаалан нарийвчилсан мэдээлэл хаалттай төдийгүй бодит тоо мэдээллийг 2022.12.25-ны өдрийг хүртэл олж авах боломжгүй байсан.

Илтгэлд дурдсанаар Өмгөөлөгчдийн холбооны Мэргэжлийн хариуцлагын хороо 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хооронд нийт 406 өргөдөл, гомдол хүлээж авснаас ажиллагаанд шалгагдаж буй 28, албан тоотоор өргөдөл, гомдлыг буцааж шийдвэрлэсэн 66, гишүүний захирамжаар хэрэгсэхгүй болгосон 31, гишүүний захирамжаар татгалзаж шийдвэрлэсэн 198, маргаан үүсгэж хурлаар шийдвэрлэсэн 83 өргөдөл, гомдол байна. Үүнээс харахад тус хороо 2022 онд 193 өргөдөл, гомдол хүлээн авснаас 89 гомдолд маргаан үүсгэхээс татгалзсан, 63 гомдолд маргаан үүсгэсэн, 31 гомдолд албан бичгээр хариу өгсөн, 10 гомдол ажиллагаанд байна. Энэ нь нийт өргөдөл, гомдлын 33 хувьд маргаан үүсгэсэн, 5 хувийг шалгаж байгаа бол 62 хувьд нь татгалзсан хариу өгсөн байх магадлалтайг харуулж байна.

График 3. Гомдол шийдвэрлэсэн байдал (2022 он)



Харин маргааныг хэрхэн шийдвэрлэсэн талаар мэдээлэл байхгүй тул харьцуулсан дүн шинжилгээ хийх боломжгүй, гэхдээ гишүүний захирамжаар хэрэгсэхгүй болгосон хэргийн тоо 25 байгаа нь өмнөх онд хэрэгсэхгүй болгосон 6 хэргийн тоотой харьцуулахад даруй 4 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Ийнхүү Мэргэжлийн хариуцлагын хороо өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүй, мэргэжлийн ур чадвар, хариуцлагатай холбоотой тэдгээрийн үйлчлүүлэгч, бусад этгээдээс гаргасан гомдлын дагуу Өмгөөллийн тухай хуулийн зохицуулалт болон Ёс зүйн дүрмийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх талаар “Зөвлөмж” гаргаж ажилладаг бөгөөд 2021, 2022 онд 2 удаа зөвлөмж гаргасан байна.

Эдгээр зөвлөмжийн агуулгыг харвал юуны өмнө Өмгөөллийн тухай хууль батлагдсантай холбоотой бүтэц, зохион байгуулалт, бүртгэл, мэдээлэлтэй холбоотой үүргээ хэрэгжүүлэх, ялангуяа өмгөөлөгч, өмгөөллийн хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой зөвлөмжийг хүргүүлсэн бол өмгөөлөгчийн ёс зүй, мэргэжлийн ур чадвар, хариуцлагатай холбоотой шүүх хуралдаанд бэлтгэлтэй оролцох, хуралд оролцох, үйлчлүүлэгчиддээ мэдээлэл хүргэх, үйлчилгээний хөлсийг бодитоор тогтоох, өмгөөллийн гэрээ байгуулах, гэрээ дүгнэх асуудалтай холбоотой зөрчил буурахгүй, харин ч нэмэгдэх хандлагатай байгааг онцлон тэмдэглэжээ.

Өмгөөлөгчдийн дунд үйлчилгээний хөлсөө бодитоор тогтоох буюу үзүүлж буй үйлчилгээний чанар, цар хүрээнд нийцсэн хөлс авч буй эсэх талаар цөөнгүй маргаан үүсгэж байгаа нь өмгөөлөгч болон үйлчлүүлэгч өмгөөллийн гэрээгээ харилцан дүгнэдэггүй, өмгөөллийн үйл ажиллагааны үе шатуудын талаар үйлчлүүлэгчдээ хангалттай мэдээлэл хүргэдэггүйтэй холбоотой байна. Түүнчлэн өөрийн үйлчлүүлэгчээс бусад этгээдтэй хүндэтгэлтэй хандах байдал ч дутмаг байгааг Мэргэжлийн хариуцлагын хорооноос гаргасан Зөвлөмжид дурджээ.

Мэргэжлийн хариуцлагын хорооны ажиллах журмын 39 дүгээр зүйлийн 39.1-д “Хорооны ажлын алба нь өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн маргааныг хянан шийдвэрлэхтэй холбогдсон журамд заасны дагуу бүртгэлээс хасах, шаардлагатайгаас бусад тохиолдолд өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн зөрчилтэй холбоотой бүртгэлийг хөтөлж, холбогдох мэдээг сар тутам, тайланг хагас жил тутамд гаргана” гэж, 39.3-т “Энэ зүйлийн 39.1-д заасан тайлан нь дараах мэдээллийг агуулсан байна:

- хүлээн авсан гомдлын тоо;
- маргаан үүсгэхээс татгалзсан гомдлын тоо;
- үүсгэсэн маргааны тоо; түдгэлзүүлсэн маргааны тоо;
- хянан шалгагч нарын маргаан хянан шийдвэрлэх болон бусад үйл ажиллагаанд оролцсон байдал;
- хянан шалгагч болон гишүүнд хуваарилагдсан маргааны тоо;
- тухайн жилд хэрэгсэхгүй болгосон маргааны тоо; нэмэлт ажиллагаа хийлгэхээр буцаасан маргааны тоо;
- хэрэгсэхгүй болгосон маргааны тоо;
- хариуцлага хүлээлгэсэн маргааны тоо;
- хүлээлгэсэн хариуцлагын төрөл;
- шүүхэд гомдол гаргасан маргааны тоо;
- шүүхээс хүчингүй болгосон маргааны тоо ...”

зэрэг мэдээллийг холбооны албан ёсны цахим хуудас дахь Мэргэжлийн хариуцлагын хороо гэх цэсэд оруулан, тогтмол ажиллуулах буюу тухайн хорооны үйл ажиллагааны тайлан, гаргасан зөвлөмж болон гишүүд, ажлын албаны үйл ажиллагааны талаар танилцуулга, мэдээлэл зэргийг цаг тухай бүрд байршуулж байх нь тус хорооны шийдвэрээр түдгэлзүүлсэн, эрхийг нь хүчингүй болгосон өмгөөлөгчдийн талаарх мэдээллийг олон нийт төдийгүй өмгөөлөгчид авахад хүндрэл үүсгэхгүй байхад анхаарах шаардлагатай байна.

Өмгөөлөгчдийн холбооны хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлантай танилцах боломж судлаач, судалгааны байгууллагад нээлттэй байх нь Өмгөөлөгчдийн холбоо үйл ажиллагаагаа сайжруулах, цаашдын авах арга хэмжээндээ шинжлэх ухааны арга зүйд үндэслэн судалгаа, нотолгоотой хандан аливаа шийдвэрээ үндэслэлтэй гаргахад нөлөөлөх учиртай. Мэдээ мэдээлэл судлаач, судалгааны байгууллагад хаалттай байх тусам хөгжлийг хойш татах, явуулж буй үйл ажиллагаа үр дүнгүй байхад нөлөөлдөг байна.

Түүнчлэн Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрмийн 53, 66 дугаар зүйлд Мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүн хянан шалгагчийн хувьд олж авсан олон нийтэд нээлттэй биш мэдээллийг задруулах, эсхүл ашиглахыг хориглосон бол 60, 61 дүгээр зүйлд хянан

шалгагчаас олон нийтэд өгөх, өгч буй мэдээллийн хязгаарлалтын талаар заасан бөгөөд эдгээр зохицуулалтаар хязгаарлагдаагүй мэдээлэл олон нийтэд ил тод байх боломжтой юм.

Өмгөөлөгчдийн холбооны дүрмийн 59 дүгээр зүйлийн 59.6-д “Энэ дүрмийн 59.5-д Мэргэжлийн хариуцлагын хорооны бусад чиг үүрэгтэй холбоотой асуудал болон өмгөөлөгчийн ёс зүйн зөрчлийн талаар гаргасан өргөдөл, гомдол, тэдгээрийн хянан шийдвэрлэсэн болон гарсан шийдвэрийн талаарх тоо мэдээлэл, судалгааг гаргуулан авахад хамаарахгүй” гэж заасан.

2.3. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ, ТУЛГАМДСАН ЗАРИМ АСУУДАЛ

Өмгөөлөгчдийн холбооны 2020 оны 10 дугаар сарын 3-ны өдөр батлагдсан Өмгөөлөгчийн ёс зүйн дүрэмд “хууль болон энэ дүрэмд заасан үүрэг, шаардлагыг зөрчсөн өмгөөлөгчийн үйлдэл, эс үйлдэхүйг ёс зүйн зөрчилд тооцно” гэж заасан. Өмгөөлөгчийн мэргэжлийн мөн чанартай холбогдох ёс зүйн хэм хэмжээ гэх ойлголтод өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагааны мөн чанарыг алдагдуулахгүй байх, хүний эрхийг хамгаалах, нийгмийн шударга ёсыг хэрэгжүүлэх, мэргэжлийнхээ нэр хүндийг дээшлүүлэх гол хүчин зүйл нь өмгөөлөгч ёс зүйн хэм хэмжээгээ баримтлах явдал байдаг.⁴⁶

Өмгөөлөгч мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх явцдаа холбогдох эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн, ёс зүйн зөрчил гаргасан асуудлаар Мэргэжлийн хариуцлагын хороонд маргаан үүсгэсэн, шийдвэрлэсэн байдлыг судалж үзэхэд Мэргэжлийн хариуцлагын хороонд ирүүлж буй нийт өргөдөл, гомдлын 50 хувийг өмгөөлөгчийн үйлчлүүлэгч, ар гэрээс, 10 гаруй хувийг шүүх, прокурорын байгууллагаас, үлдсэн 40 орчим хувийг бусад этгээдээс буюу эсрэг талын өмгөөлөгч, тэдгээрийн үйлчлүүлэгчдээс гаргажээ.

⁴⁶ С.Нарангэрэл, “Хүний эрх, өмгөөлөл”, 1998. [С.Мягмарсүрэн, “Өмгөөлөгчдийн холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны бүрэлдэхүүний талаарх тулгамдсан асуудал”, 2022, илтгэлээс дам эшлэв.]


Мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүний танилцуулсан мэдээллээс харахад өмгөөлөгчийн ёс зүйн зөрчил гаргаж буй шалтгаан нь үндсэн 4 бүлэгт хуваагдаж байгаа бөгөөд эдгээр нь нэгд, өмгөөлөгчийн хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх гэрээтэй холбоотой буюу гэрээнд заасан үйл ажиллагааг бүрэн гүйцэтгэсэн эсэх, гэрээний үнийн дүнг маргасан шинжтэй, хоёрт, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бэлтгэл хангаж, шүүх хуралдааны товлосон цагт оролцох үүрэгтэй холбоотой, гуравт, үйлчлүүлэгч болон хэргийн бусад оролцогч, гуравдагч этгээдийн эрхийг зөрчихтэй холбоотой, дөрөвт, өмгөөллийн хуулийн этгээдтэй холбоотой гомдол байна.

График 4. Мэргэжлийн хариуцлагын хороонд ирцүлж буй гомдлын агуулга




Судалгааны багийн зүгээс өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ авсан иргэдээс өмгөөлөгчийн ёс зүй, мэргэжлийн ур чадвар, хариуцлагатай холбоотой хэд хэдэн асуудлаар судалгаа авсан бөгөөд үүний үр дүн Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан шийдвэрлэсэн байдалтай нийцэж буй эсэхийг танилцуулъя.

График 5. Судалгаанд оролцогч (аймгаар)




Судалгаанд нийт 53 хүн оролцсоноос 21-50 насныхан 94.3 хувийг эзэлсэн бөгөөд тэдгээрийн 67.9 хувь нь эмэгтэй байв. Мөн оршин суугаа газрын хувьд 51.9 хувь нь Улаанбаатар хот, бусад 48 хувь нь орон нутагт амьдардаг.

График 6. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин




Судалгаанд оролцогчдын боловсролын түвшнийг авч үзвэл 79.2 хувь нь дээд, 15.1 хувь нь бүрэн дунд боловсролтой иргэд байв. Үүнээс харахад иргэдийн боловсролын түвшин ахих тутам хууль зүй, өмгөөллийн туслалцааг мэргэжлийн хүнээс буюу өмгөөлөгчөөс авах хандлага өндөр байна. Ялангуяа судалгаанд оролцсон иргэдийн дийлэх болох 62.3 хувь өөрт хэрэгтэй, хууль зүйн мэдээллээ мэдээллийн эх сурвалж болох телевиз, радио, төрийн байгууллага, сонин сэтгүүл, найз нөхөд зэргээс илүүтэй цахим орчноос олж авдаг гэж хариулсан нь боловсролын түвшинтэй мөн адил хамааралтай байна.

График 7. Хүний эрхийн зөрчил



Судалгаанд оролцсон иргэдийн хувьд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх хамгийн ихээр зөрчигдөж байна гэж үзсэн бөгөөд эрүүл мэндээ хамгаалуулах, халдашгүй байх эрхийн зөрчил өндөр байна гэж үзсэн байна.

График 8. Хүний эрх зөрчдөг этгээд



Судалгааны дүнгээс харахад иргэдийн 39.6 хувь нь иргэд өөрсдөө бие биеийнхээ эрхэд халддаг гэж хариулсан бол 37.7 хувь нь төрийн захиргааны албан тушаалтан, 17 хувь нь хуулийн байгууллагын ажилтан, алба хаагч, 5.7 хувь нь бусад этгээд илүү ихээр хүний эрхийг зөрчдөг гэж хариулжээ. Мөн “хууль” гэдэг нь “шударга ёс” юм гэж судалгаанд оролцогчдын 83 хувь нь хариулжээ. Үүнээс харахад иргэдийн 56.6 хувь нь төрийн болон хуулийн байгууллагын албан тушаалтан хүний эрхийг зөрчдөг гэж хариулсан нь эдгээр байгууллагад оршин байгаа хүнд суртал, харилцаа, хандлага, ёс зүйгүй байдал иргэдийн төр, төрийн байгууллагад итгэх итгэлийг бууруулахад нөлөөлж байгааг харуулж байна.

График 9. Хууль зүйн туслалцаа авах эрх



Өмгөөлөгчийн ёс зүй, мэргэжлийн хариуцлагад хамаарах бүлэг асуултаас харахад иргэд ямарваа нэг хууль зүйн асуудал тулгарсан тохиолдолд өмгөөлөгчөөс тусламж авахыг илүүд үзэх бөгөөд тодорхой нэг чиглэлээр мэргэшсэн өмгөөлөгч асуудлыг шийдвэрлэхэд чухал нөлөөтэй гэж үзэх боловч өнөөгийн хууль эрх зүйн орчин, хууль хэрэглээ хангалтгүй, хууль зүйн туслалцаа авах боломжтой ч эрхээ хамгаалуулах нөхцөл бүрдээгүй зэрэг шалтгаанаар эрхээ бүрэн эдэлж чаддаггүй гэж үзэж байна.


График 10. Өмгөөлөгчөөс туслалцаа авч байсан эсэх



“Та эрхээ хамгаалуулахаар өмгөөлөгчид хандаж байсан уу?” гэж асуултад судалгаанд оролцогчид бүгд хариулсан бөгөөд тэдгээрийн 36 хувь буюу 3 хүн тутмын нэг нь өмнө нь өмгөөлөгчид хандаж байсан бол 64 хувь нь хандаж байгаагүй байна. Харин өмгөөлөгчид хандаж буй үйлчлүүлэгчдийн 30 хувь нь гэрээ байгуулсан, 33 хувь нь гэрээ байгуулаагүй, 37 хувь нь анхан шатны зөвлөгөө, мэдээлэл авсан тул гэрээ байгуулах шаардлага байгаагүй гэж хариулжээ.

Үүнээс харахад өмгөөлөгчөөс хууль зүйн болон өмгөөллийн туслалцаа авч буй иргэдийн 66.6 хувь нь өмгөөллийн буюу хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулалгүйгээр үйлчилгээ авдаг байна. Үүнээс үүдэн өмгөөлөгч, үйлчлүүлэгчийн дунд маргаан үүсэх нь түгээмэл байгаа ба Өмгөөлөгчдийн холбооны Мэргэжлийн хариуцлагын хороонд гаргаж буй нийт гомдлын 71 хувь нь өмгөөллийн гэрээ, түүний биелэлттэй холбоотой байгаа нь өмгөөллийн гэрээ байгуулаагүйгээс үүсэж байгааг илтгэж байна.

График 11. Өмгөөлөгчийн ёс зүйд өгөх үнэлгээ




Судалгаанд оролцсон 50 иргэний 42.6 хувь нь өмгөөлөгчийн ёс зүй өндөр түвшинд байдаг гэж үнэлсэн бол 36 хувь нь дунд зэрэг, 21.3 хувь нь хангалтгүй, анхаарах шаардлагатай гэж хариулснаас

харахад өмгөөлөгчөөс үйлчилгээ авсан иргэдийн 2,3 хүн тутмын нэг нь өмгөөлөгчийнхөө ёс зүйд сэтгэл хангалуун, 4 хүн тутмын нэг нь ёс зүйн хувьд асуудалтай өмгөөлөгчөөр үйлчлүүлсэн байна.

Дээрх асуудлыг буюу ёс зүйн хувьд хангалтгүй, анхаарах шаардлагатай гэж хариулсан үйлчлүүлэгчдийн 85 орчим хувь нь тодорхой шалтгаан заагаагүй бол 4.4 хувь нь бусдыг доромжилдог, 4.4 хувь нь бусдыг дарамталдаг, 4.4 хувь нь амлалт өгсөн ч түүндээ хүрээгүй, 2.2 хувь нь эсрэг талд үйлчилсэн тул өмгөөлөгчдийн ёс зүйд анхаарах шаардлагатай гэжээ.

График 12. Өмгөөлөгч хараат бусаар хуульд захирагдан ажилладаг эсэх




Хэдийгээр хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хууль эрх зүйн орчин хангалтгүй, өмгөөлөгчдийн хууль хэрэглээний ур чадвар дутмаг гэж үнэлж байгаа ч өмгөөлөгчид зөвхөн хуульд захирагддаг гэж үзэх иргэдийн эзлэх хувь 71.4 байгаа нь өмгөөллийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах нөхцөл сайн байгааг илтгэж байна.

График 13. Хууль хэрэгжихгүй байх шалтгаан



Өмгөөлөгчөөс үйлчилгээ авсан иргэд өмгөөлөгчийнхөө ёс зүй, мэргэжлийн ур чадварт өгсөн үнэлгээнээс харахад 2 хүн тутмын нэг нь өмгөөлөгчийн ур чадварт сэтгэл хангалуун байгаа бол үлдсэн хэсэг нь өмгөөлөгчдөө эргэлзсэн, үнэлж мэдэхгүй байгаа нь анхаарах асуудлын нэг байна.

График 14. Хуулийн үйлчлэл



Өмгөөлөгч эрх мэдэл, хөрөнгөтэй хүнд илүү үйлчилдэг бөгөөд хуулийн зөрчилтэй байдал, хууль хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагаа хангалтгүй, хуульчид авлигад өртөмтгий зэрэг нь дээрх нөхцөлийг бүрдүүлэх хүчин зүйл болдог гэж үзэж байна. Түүнчлэн хууль хүн бүрт тэгш үйлчилдэг гэж иргэдийн 1.9 хувь үзэж байгаа нь маш бага буюу иргэдийн хууль хяналтын болон төрийн байгууллагын үйл ажиллагаанд итгэх итгэл сул, тэгш бус байгааг харуулж байна.

ГУРАВ. ГАДААД ОРНЫ ТУРШЛАГА

Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн хариуцлага хүлээлгэх механизм хэрхэн ажилладаг талаар Ром германы тогтолцоо, Англи саксоны тогтолцоотой өндөр хөгжилтэй улсаас Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Америкийн Нэгдсэн Улс, Япон улсыг төлөөлөл болгон сонгон авч харьцуулан судаллаа.

3.1. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ)-д нийт 16,000 гаруй хууль (Rechtsanwalt) үйлчилдэг. Тус улсын хуульчид мужийн хуульчдын холбоо эсхүл Холбооны дээд шүүхэд харьяалагддаг. Мужийн хуульчдын 27 холбоо байдаг.⁴⁷ Холбооны хуульчийн тухай хууль (Federal Lawyers' Act)-иар хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг зохицуулдаг. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа нь хараат бус байх зарчмын үндсэн дээр явагдана.

3.1.1. Сахилгын хэрэг хянан шалгадаг институт, сахилгын шийтгэл

Хуульчийн гаргасан сахилгын зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагаанд Холбооны хуульчдын холбоо ямар нэг байдлаар оролцдоггүй. Харин мужийн хуульчдын холбоо нь хуульч мэргэжлийн үйл ажиллагааны хэм хэмжээг дагаж мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих ба зөвхөн тодорхой төрлийн хариуцлагын арга хэмжээ авах эрхтэй. Холбооны Хуульчдын тухай хуулийн 113 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хуульч нь тус хууль болон мэргэжлийн үйл ажиллагааны дүрмийг зөрчсөн нь тогтоогдвол Хуульчийн сахилгын шүүх уг асуудлыг хянан шийдвэрлэж, сахилгын шийтгэл ногдуулах эсэхийг тогтоодог.

⁴⁷ European E-Justice, Types of Legal Profession: Germany. https://e-justice.europa.eu/29/EN/types_of_legal_professions?GERMANY&member=1

Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дүнд хуульч нь зөрчил гаргасан нь тогтоогдвол дараах шийтгэлийг оногдуулдаг.⁴⁸

- Сануулах;
- Бичгээр сануулах;
- 25,000 евро хүртэл торгох;
- Эрх зүйн тодорхой салбарт үйлчлүүлэгчийг төлөөлөх эрхийг 1-5 жилээр хязгаарлах;
- Хуульчийн эрхийг хасах.

Эдгээрээс бичгээр сануулах, торгууль зэрэг шийтгэлийг нэмэлт хэлбэрээр давхардуулан оногдуулж болно.⁴⁹

Хуульчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сахилгын шүүх, хуульчдын давж заалдах шүүх, дээд шүүх тус тус хянан хэлэлцэнэ. Сахилгын шүүхийг мужийн хуульчдын холбоо тус бүрд байгуулна.⁵⁰ Сахилгын шүүх нь дотроо танхимтай байж болох ба танхимын тоог мужийн Хууль зүйн яам тогтоож, сахилгын шүүхийн үйл ажиллагаанд хяналт тавина.⁵¹ Сахилгын шүүх нь даргалагч шүүгч болон бусад гишүүдээс бүрдэх ба даргалагч хэд хэдэн шүүгчтэй тохиолдолд тэдгээрийн нэгийг Ерөнхий шүүгчээр томилно. Уг шүүхийн шүүгчдийг мужийн хуульчдын холбооны саналын үндсэн дээр Хууль зүйн яам томилдог.⁵² Хууль зүйн яам нь тухайн шүүхийн гишүүдийн тоог тогтооно. Мужийн хуульчдын холбоо нь уг тооноос 50 хувиар илүү тооны хуульчдын нэрсийг хууль зүйн яаманд санал болгох ба эдгээрээс томилгоог 5 жилийн бүрэн эрхийн хугацаатайгаар хийнэ. Сахилгын шүүхэд дараах хуульчдыг томилохгүй:

- Мужийн хуульчдын холбооны удирдах зөвлөл, эсхүл их хурлын гишүүн;

⁴⁸ Холбооны хуульчдын тухай хуулийн 114 дэх хэсгийн 1 дэх заалт. https://www.gesetze-im-internet.de/englisch_brao/englisch_brao.html#p0777

⁴⁹ Мөн тэнд.

⁵⁰ Мөн тэнд 92.1.

⁵¹ Мөн тэнд 92 дугаар зүйлийн 3.

⁵² Мөн тэнд, 93 дугаар зүйлийн 1-2, 94 дүгээр зүйлийн 2.

- Үндсэн эсхүл дагалдах шинжтэйгээр аль нэг хуульчдын холбоонд ажил эрхэлдэг;
- Өөр сахилгын шүүхийн гишүүн.

Хуульчдын давж заалдах шатны шүүхийг мужийн давж заалдах шатны шүүх тус бүрд байгуулна. Уг шүүх нь тэргүүн, даргалагч шүүгч, бусад гишүүдээс бүрдэх ба тэргүүн, даргалагч шүүгч шүүгчид тавигдах болзол, шаардлагыг хангасан байна.⁵³ Хуульчдын давж заалдах шатны шүүхийн шүүгч болон хуульч гишүүдийг мужийн хууль зүйн яам томилно.

Холбооны дээд шүүхийн дэргэд хуульчийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх бүрэлдэхүүн ажиллана. Уг бүрэлдэхүүнд Холбооны дээд шүүхийн Ерөнхий шүүгчээс гадна тус шүүхийн хоёр шүүгч, хоёр хуульч багтана. Хуульч гишүүдийн хувьд туслах шүүгчийн чиг үүрэгтэй байх ба Холбооны хууль зүй, хэрэглэгчийн эрхийг хамгаалах яамнаас 5 жилийн бүрэн эрхийн хугацаатайгаар томилно.

3.1.2. Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

Үйлчлүүлэгч хуульч мэргэжлийн үйл ажиллагааны хэм хэмжээг зөрчсөн тухай гомдлыг мужийн хуульчдын холбоо, эсхүл прокурорын байгууллагад гаргана. Гомдол гаргахтай холбоотой хөөн хэлэлцэх хугацаа байхгүй.

Гомдлыг бичгээр холбооны Ерөнхийлөгчид хандан гаргана. Мужийн хуульчдын холбооны удирдах зөвлөл (тухайн мужийн хуульчдаас сонгогдсон 7 гишүүний бүрэлдэхүүнтэй) тухайн гомдолд дурдсан зөрчлийн шинж чанар, хуульчийн буруутай, илтэд хайхрамжгүй үйлдэл гаргасан эсэхийг нягтлаад ялимгүй зөрчлийн шинжтэй бол Сахилгын шүүхэд шилжүүлэхгүйгээр сануулах арга хэмжээ авдаг. Энэхүү арга хэмжээ нь ялимгүй зөрчилд холбогдуулан сахилгын шүүх ажиллагаа явуулж, зардал гаргахаас урьдчилан сэргийлэх зорилготой.

⁵³ Мөн тэнд 101 дүгээр зүйлийн 1.

Ялимгүй зөрчил гэж үзэн сануулах арга хэмжээ авсан нь тухайн мужийн прокурорын байгууллагаас хуульчийн тухайн үйлдэлд холбогдуулан сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлүүлэхэд саад учруулахгүй. Учир нь прокурорын байгууллага нь мөн хуулийн 120 дугаар зүйлд зааснаар сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд яллах чиг үүрэгтэйгээр оролцдог субъект⁵⁴ бөгөөд энэ тохиолдолд хуульчдын холбоо гишүүнийхээ гаргасан зөрчлийг нуун дарагдуулах, хариуцлага завшуулах зэргээс хамгаална.

Хэрэв тухайн зөрчлийг сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дүнд шийдвэрлэх нь зүйтэй гэж үзвэл сахилгын хэрэг үүсгэнэ. Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь прокурорын байгууллагаас тухайн хуульчийг зөрчил гаргасан гэж үзэн дүгнэлт гаргаснаар эхэлнэ.⁵⁵ Прокурорын дүгнэлтэд буруутгаж буй хуульчийн үйлдэл, тухайн үйлдлийг гаргасан үйл баримт зэргээс гадна эдгээрийг нотлох баримтыг нэрлэн дурдсан байна.⁵⁶

Хуульд заасан хэм хэмжээг хуульч нь зөрчсөн байж болзошгүй тохиолдолд прокурорын байгууллага болон хуульчдын холбоо уг мэдээллийг нэн даруй солилцох үүргийг хуулиар хүлээдэг.⁵⁷ Тодруулбал, хуульчийн гаргасан байж болзошгүй зөрчлийн талаар аль аль байгууллага ижил мэдээлэлтэйгээр хуульд заасан ажиллагааг хийнэ.

Сахилгын шүүх нь прокурорын байгууллагын дүгнэлтийг хүлээн авч шийдвэрлэнэ. Хуульч энэ үе шатанд сахилгын шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхгүй. Сахилгын шүүх хэрэг үүсгэхээс татгалзсан шийдвэрийг хангалттай үндэслэлтэй гаргах ба энэ тохиолдолд прокурорын байгууллага нь уг шийдвэрийг давж заалдах эрхтэй.⁵⁸

⁵⁴ Мөн тэнд.

⁵⁵ Мөн тэнд, 121 дүгээр зүйл.

⁵⁶ Мөн тэнд, 130 дахь зүйл.

⁵⁷ Мөн тэнд, 120а дахь зүйл.

⁵⁸ Мөн тэнд, 131 дүгээр зүйл.

Сахилгын шүүх нь хуульчид холбогдох сахилгын хэргийг хуралдаанаар хянан шийдвэрлэнэ. Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Эрүүгийн процессын хуулийг төсөөтэй хэрэглэнэ. Хуульчид сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх мэдэгдлийг өгсөн боловч ирээгүй бол түүний эзгүйд хэргийг хянан шийдвэрлэнэ. Ямар ч тохиолдолд хуульчийг албадан ирүүлэх тухай мэдэгдлийг олон нийтэд нээлттэйгээр зарлахгүй.⁵⁹

Сахилгын хэргийн шүүх хуралдаан прокурор, эсхүл тухайн хуульч хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд хаалттай явагдана.⁶⁰ Харин хуралдаанд мужийн хууль зүйн яамны албан хаагч, мужийн дээд шүүхийн тэргүүн, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч, прокурорын байгууллагын албан хаагчид, мужийн хуульчдын холбооны албан хаагчид оролцож болно.

Сахилгын шүүх нь аль нэг шүүгчид гэрч, шинжээчээс мэдүүлэг авах үүрэгтэйгээр даалгаж болно. Мөн өөр мужид байгаа ижил шүүхэд дээрх чиг үүргийг хуваарилж болно. Прокурор, эсхүл хуульч нь тухайн гэрч, шинжээчийг шүүх хуралдаанд оролцуулах хүсэлт гаргасан бол эдгээр субъектийг оролцуулж болно. Харин гэрч, шинжээч нь шүүх хуралдаанд оролцох боломжгүй, эсхүл оролцохын тулд холоос ирэхээр бол эдгээр субъектийг оролцуулахгүй байж болно.⁶¹

Шүүх хуралдааны явцад болон шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх өөр ажиллагаанд тухайн хэрэгт хамааралтай гэрч, шинжээчийн мэдүүлгийн тэмдэглэл хийгдсэн бол түүнийг сахилгын шүүх оролцогчдод уншиж сонсоно.

Сахилгын шүүх шийдвэр гаргахын өмнө прокурор болон хуульч гэрч, шинжээчийг дуудан ирүүлж мэдүүлэг авах хүсэлт гаргаж болох ба шүүх хүсэлтийг хүлээн авсан бол тэдний өмнө өгсөн мэдүүлгийг нь уншиж сонсохгүй байж болно. Эдгээр гэрч, шинжээчээс хуульд заасны дагуу шүүгч томилогдон очиж мэдүүлэг авсан бол энэ

⁵⁹ Мөн тэнд, 134 дүгээр зүйл.

⁶⁰ Мөн тэнд, 135 дугаар зүйлийн 1.

⁶¹ Мөн тэнд, 137 дугаар зүйл.

хүсэлтийг хэрэгсэхгүй болгож, мэдүүлгийг уншиж сонгоно.⁶²

Сахилгын шүүх нь хэргийн хянан хэлэлцээд дараах шийдвэрийн аль нэгийг гаргана.⁶³

- Шийтгэх тогтоол
- Цагаатгах тогтоол
- Сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох.

Дараах үндэслэлээр сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгож болно.⁶⁴

- Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрх нь дуусгавар болсон;
- Тухайн зөрчилд холбогдуулан шүүх эсхүл эрх бүхий этгээдээс шийтгэл ногдуулсан.

Сахилгын шүүх шийдвэрээ гаргасны дараа хуульч давж заалдах гомдлыг Холбооны дээд шүүхэд бичгээр гаргаж болно.⁶⁵ Сахилгын шүүхийн шийдвэрийг уншиж сонгосны дараа 7 хоногийн дотор гомдлоо гаргана. Хэрэв хуралдаанд хуульч оролцоогүй бол шийдвэрийг хүргүүлсний дараа уг хугацааг тоолно. Давж заалдах шатны гомдлыг үйл баримтын болон хууль хэрэглээний аль аль асуудлаар гаргаж болно.⁶⁶ Давж заалдах шатны шүүхийн үйл ажиллагаа нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу явагдана. Давж заалдах шатны журмаар сахилгын хэргийг хянан шийдвэрлэхэд мужийн дээд прокурорын газар нотлох үүрэгтэйгээр оролцоно.

Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг эс хүлээн зөвшөөрвөл дараах тохиолдолд мужийн дээд шүүхэд гомдол гаргаж болно.⁶⁷

⁶² Мөн тэнд, 138 дугаар зүйл.

⁶³ Мөн тэнд, 139 дүгээр зүйлийн 1.

⁶⁴ Мөн тэнд, 139 дүгээр зүйлийн 3.

⁶⁵ Мөн тэнд, 142 дугаар зүйл.

⁶⁶ 143 дугаар зүйлийн 1.

⁶⁷ Мөн тэнд, 145 дугаар зүйлийн 1.

- Сахилгын шүүхийн шийдвэрийн үр дүнд сахилгын шийтгэл ногдуулсан;
- Шүүх прокурорын мэдэгдлээс эсрэгээр, хуульд заасан арга хэмжээг аваагүй;
- Хууль хэрэглээний асуудлаар гомдол гаргаж болохыг давж заалдах шатны шүүхийн шийдвэрт дурдсан.

Хуульчийн суурь шинжтэй мэргэжлийн үйл ажиллагааны асуудлаар шийдвэр гаргасан бол давж заалдах шатны шүүх шийдвэртээ хууль хэрэглээний асуудлаар гомдол гаргах эрхийг тусгаж болно.

3.2. АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

АНУ-д хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчлийг шалгах, нотлох, шийдвэрлэх ажиллагааны зохицуулалт нь муж тус бүрд харилцан адилгүй байна. Тус улсын Хуульчдын холбооноос нийтлэг жишгийг багтаасан Хуульчийн сахилга сахиулах загвар журам (Model Rules on Disciplinary Enforcement)-ыг 1989 онд баталсан бөгөөд ихэнх муж уг загвар журамд үндэслэн баталсан журмаар хуульчийн сахилгын зөрчлийг шалгаж шийдвэрлэдэг.⁶⁸ Сахилгын зөрчил гаргасан гэж үзэж байгаа тохиолдолд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг шууд хасахгүй. Шударга ёсны зарчмыг хангасан хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн дээр шийдвэр гаргадаг ажээ. Тодруулбал, буруутгагдаж буй хуульчид түүнийг буруутгаж буй зөрчлийн талаарх дүгнэлтийг урьдчилан танилцуулах, өмгөөлүүлэх, гэрчийг байцаах боломж олгох, өөрийн тайлбар, үндэслэлийг ажиллагааны явцад гаргах, гарсан шийдвэрийг давж заалдах зэрэг эрхтэй байна.

Дээр дурдсан загвар журмын дагуу хуульчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дэлгэрүүлэн авч үзье.

⁶⁸ Америкийн Хуульчдын холбооны албан ёсны цахим хуудаст байршсан хувилбар
https://www.americanbar.org/groups/professional_responsibility/resources/lawyer_ethics_regulation/model_rules_for_lawyer_disciplinary_enforcement/

3.2.1. Сахилгын хэргийг хянан шийдвэрлэдэг институт, сахилгын шийтгэл

Загвар журамд Сахилгын хороо, сахилгын хэрэг хянан хэлэлцэх бүрэлдэхүүн, сахилгын зөвлөх, шүүх зэрэг субъектийг тусгайлан заажээ.

Сахилгын хороо: Тухайн мужийн хэмжээнд хуульчийн мэргэжлийн хариуцлагын асуудлыг хариуцдаг институтийг Сахилгын хороо гэх бөгөөд тус хороог мужийн шүүхээс 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр, бүрэн эрхийн хугацааг сөөлжлүүлэн томилдог. Нийт гишүүдийн 6 нь тухайн хуульчдын холбооны гишүүн бол 3 нь олон нийтийн төлөөлөл байна. Олон нийтийн төлөөллийг эхний удаа томилохдоо бүрэн эрхийн хугацааг нэг, хоёр, гурван жил байхаар ялгамжтай тогтоох ба дараагийн томилгооноос эхлэн 3 жилийн бүрэн эрхийн хугацаатайгаар тогтооно. Хороо нь хуульчийн сахилгын хэргийг хянан хэлэлцэх журмыг санал болгох, сахилгын тогтолцоог тогтмол үнэлж дүгнэх, сахилгын хэрэг хянан хэлэлцэх 3 буюу түүнээс дээш бүрэлдэхүүнийг томилох зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Сахилгын хэрэг хянан хэлэлцэх бүрэлдэхүүн: Бүрэлдэхүүн нь гурван гишүүнтэй байх ба үүний хоёр нь хуульч, нэг нь олон нийтийн төлөөлөл байна. Хуульч гишүүдийн аль нэгийг даргалагчаар томилно. Бүрэлдэхүүн нь Хорооны адилаар бүрэн эрхийн хугацааг сөөлжлүүлж томилогдоно. Сахилгын хэрэг хянан хэлэлцэх бүрэлдэхүүн нь хуульчийг зөрчил гаргасанд тооцох дүгнэлт бүхий сахилгын хэргийг хянан хэлэлцэх, хорооны даргалагчаар дамжуулан сахилгын зөвлөхийн саналыг хянаж, батлах, эсхүл өөрчлөлт оруулах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Сахилгын зөвлөх: Шүүхээс сахилгын зөвлөхөөр хуульчийг томилох бөгөөд уг зөвлөх нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхгүй. Сахилгын зөвлөх нь зөрчлийг нотлох (“Яллах”) чиг үүрэгтэй ажиллах бөгөөд хуульчийн сахилгын зөрчилтэй холбоотой мэдээллийг цуглуулан үнэлэх, сахилгын шийтгэл ногдуулахтай холбогдсон асуудлыг мөрдөн шалгах, сахилгын хэрэг хянан хэлэлцэх хуралдаанд нотлох чиг үүрэгтэй оролцох, мөрдөн шалгалтын үр

дүнгийн талаар гомдол гаргагчид мэдэгдэх зэрэг чиг үүрэгтэй. Сахилгын зөвлөх нь албан ёсоор дүгнэлт гаргаж, сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэхийн өмнө сахилгын хэрэг хянан хэлэлцэх хорооны даргын зөвшөөрснөөр, дүгнэлт гарсны дараа өөрийн санаачилгаар зөрчлийг нотлох баримт цуглуулна. Гэрчийг дуудаж мэдүүлэг авах, нотлох баримт гаргуулах зэрэг шийдвэрийн биелэлтийг шүүх хангуулдаг.

3.2.2. Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

Сахилгын зөвлөх (disciplinary counsel) ажиллах бөгөөд сахилгын зөрчлийг нотлох чиг үүрэгтэй байна.⁶⁹ Сахилгын зөвлөх нь хуульч сахилгын зөрчил гаргасан, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх чадваргүй болсон тухай өргөдөл, мэдээлэл болон бусад эх сурвалжаас тодруулж, үнэлнэ.⁷⁰ Хэрэв уг мэдээлэл нь сахилгын зөрчлийн шинжгүй бол энэ тухай хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны байгууллагад мэдэгддэг. Харин сахилгын зөрчлийн шинжтэй асуудлын хувьд мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг.⁷¹

Сахилгын зөвлөх мөрдөн шалгах ажиллагааг удирдан явуулах ба мөрдөн шалгах ажиллагааны дүнд а/ хэрэгсэхгүй болгох, б/үр дүнг тухайн хуульчид хүргүүлж, тусгай журмаар сахилгын хэргийг шийдвэрлүүлэх, в/тэнсэн хяналт тавих, сануулахыг санал болгох болгох, тухайн хуульчийг хариуцлагад татах гэсэн шийдвэрийн аль нэгийг гаргана.⁷² Хэрэгсэхгүй болгохоос бусад шийдвэр гаргах тохиолдолд тухайн хуульчид мэдэгдэж, тайлбар өгөх боломжоор хангана.

Сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох, сахилгын тусгай журмаар хэргийг шийдвэрлүүлэхээс бусад тохиолдолд сахилгын зөвлөлөөс байгуулагдсан гурван гишүүний бүрэлдэхүүн уг саналыг хянан үзнэ. Сахилгын зөвлөхийн саналыг тогтоосон дарааллын дагуу

⁶⁹ Хуульчийн сахилгыг сахиулах загвар журмын 18.4.

⁷⁰ Мөн журмын, 11.1.

⁷¹ Мөн тэнд.

⁷² Мөн тэнд, 2.1.

томилогдсон даргалагч хянана. Сахилгын зөрчлийн талаар явуулсан шалгалтын дүнгийн талаар гомдол гаргагчид мэдэгдэнэ. Сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох талаар санал гаргасан бол гомдол гаргагч нь 30 хоногийн дотор уг саналыг дахин хянуулах хүсэлт гаргаж болно. Даргалагч сахилгын зөвлөхийн саналд өөрчлөлт оруулж болох ба уг өөрчлөлтийг эс зөвшөөрвөл сахилгын зөвлөх нь хорооноос томилогдсон өөр бүрэлдэхүүнээр уг өөрчлөлтийг хянуулах хүсэлт гаргаж болно. Даргалагч нь сахилгын зөвлөхийн саналыг хянасан бүрэлдэхүүнд тухайн асуудлыг цааш хянан шийдвэрлэхэд оролцохгүй.

Сануулах, эсхүл тэнсэн хяналт тавих сахилгын шийтгэл ногдуулах тохиолдолд сахилгын зөвлөх нь эдгээр шийтгэлийн талаар болон уг асуудлыг сахилгын хэрэг хянан хэлэлцэх хуралдаанаар шийдвэрлүүлэх саналаа 14 хоногийн дотор гаргах талаар тухайн хуульчид мэдэгдэнэ. Хуульч нь заасан хугацаанд санал хүсэлтээ гаргаагүй бол сануулах, тэнсэн хяналт тавих сахилгын шийтгэлийг үг дуугүй хүлээн зөвшөөрсөнд тооцно.⁷³ Харин сахилгын хэргийг хуралдаанаар хянан шийдвэрлүүлэх хүсэлт гаргасан тохиолдолд албан ёсоор буруутгасан дүгнэлт (formal charge) гаргах ажиллагаа эхэлнэ.

Сахилгын зөвлөх нь буруутгах дүгнэлтийг бичгээр бэлтгэж, Сахилгын хороонд танилцуулж, асуудалд холбогдсон хуульчид нэг хувийг хүргүүлнэ. Хуульч нь түүнийг буруутгаж буй үндэслэлд холбогдох хариу тайлбараа 20 өдрийн дотор бэлтгэж, Хороонд хүргүүлнэ. Ийнхүү тайлбар ирүүлээгүй бол хүлээн зөвшөөрсөнд тооцно. Хуралдаанд оролцуулах тухай мэдэгдлийг 25-аас доошгүй өдрийн өмнө мэдэгдэнэ. Мэдэгдэлд өмгөөлүүлэх, гэрчийг асуух, нотлох баримт гаргаж өгөх зэрэг хуульчийн эрхийг тусгасан байна. Гомдол гаргагч нь мөн хуралдаанд оролцож, тухайн хуульчийн сахилгын зөрчлийн талаар болон түүний улмаас өөрт учирсан хор хохирлын талаар мэдүүлж болно. Тухайн хуульчийн өмнөх сахилгын шийтгэлийн талаар түүний зөрчлийг нотолж тогтоох хүртэл бүрэлдэхүүнд танилцуулахгүй. Хэргийг хянан хэлэлцсэн бүрэлдэхүүн нь хэргийг хэрэгсэхгүй болгох, эсхүл хуульчид

⁷³ Мөн тэнд, 3.1.

сахилгын шийтгэл ногдуулах талаарх саналаа тусгасан тайланг бэлтгэж, танилцуулна.

Хэрэг хянан хэлэлцэх бүрэлдэхүүний саналыг эс зөвшөөрвөл хуульч, эсхүл сахилгын зөвлөх нь 20 өдрийн дотор гомдлоо Хороонд хандан гаргаж болно. Мөн хорооны бүрэлдэхүүний олонх нь тухайн асуудлыг дахин хянаж үзэх нь зүйтэй гэж үзвэл хянан үзэж болно.⁷⁴

Хороо хэрэг хянан хэлэлцсэн бүрэлдэхүүний саналыг батлах, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох шийдвэрийн аль нэгийг гаргана. Сахилгын шийтгэл ногдуулах, эсхүл хэргийг хэрэгсэхгүй болгох талаар тодорхой саналаа тусгасан шийдвэрийг бэлтгэх бөгөөд уг шийдвэрийг шүүхэд болон тухайн хуульч, сахилгын зөвлөхөд хүргүүлнэ. Энэ шатанд Хороо нь хэрэг хянан хэлэлцэх бүрэлдэхүүний хуралдаанд хэлэлцэгдээгүй шинэ нотлох баримтыг шинжлэн судлахгүй. Учир нь бүрэлдэхүүн нь анхан шатны журмаар үйл баримтыг тогтоох, Хороо нь давж заалдах шатны журмаар хянах чиг үүргийг хэрэгжүүлнэ.⁷⁵

Шүүх нь хуульч, сахилгын зөвлөхөөс гаргасан эсэргүүцэл, эсхүл өөрийн санаачилгаар сахилгын хэргийг хянан шийдвэрлэж болно. Шүүх сахилгын хэргийг эцэслэн шийдвэрлэхээр тогтоосон бол хуульч болон сахилгын зөвлөх нь үүнээс хойш 60 өдрийн дотор холбогдох тайлбар үндэслэлээ бэлтгэж шүүхэд хүргүүлнэ. Шүүх өмнө хэлэлцэгдээгүй шинэ нотлох баримтыг хэлэлцэхгүй бөгөөд хэрэгт цугласан баримтад тулгуурлан шийдвэрээ бичгээр гаргана. Шинээр илэрсэн нөхцөл байдал үүссэн тохиолдолд хэргийг хянан хэлэлцсэн бүрэлдэхүүн рүү буцаана.⁷⁶

Сахилгын хэрэг үүсгэн шалгахад хөөн хэлэлцэх хугацааны асуудал хөндөгдөх нь тохиромжгүй гэж үздэг. Мэргэжлийн үйл ажиллагааны алдаа дутагдал нь хэзээ үйлдэгдсэнээс үл хамаараад хуульчийн мэргэжлээр ажиллах боломжтой эсэх эргэлзээг дагуулж байдаг тул зөрчлийг шалгах ажиллагаанд хөөн хэлэлцэх хугацаа хамаардаггүй.

⁷⁴ Мөн тэнд, 5.

⁷⁵ Мөн тэнд, 5(2).

⁷⁶ Мөн тэнд, 6.

Мөн тус загвар журамд тусгай журмаар шийдвэрлэх ажиллагааны талаар тусгажээ (Alternatives to Discipline Program). Хуульчийн талаар ирүүлсэн гомдлын дийлэнх нь ялимгүй шинжтэй зөрчлийн талаар байдаг бөгөөд эдгээр гомдлын мөн дийлэнх хэсэг нь хэрэгсэхгүй болдог. Ийнхүү ирсэн гомдлын дийлэнхийг хэрэгсэхгүй болгох нь хуульчийн мэргэжлийн хариуцлагын тогтолцоонд итгэх олон нийтийн итгэлийг ихээхэн бууруулдаг тул захиргааны шинжтэй тодорхой арга хэмжээ авах ёстой.⁷⁷ Үйлчлүүлэгчид учирсан хохирлыг эвийн журмаар төлүүлэх, сэтгэл зүйн үйлчилгээ, хуульчид дэмжлэг үзүүлэх механизм, үргэлжилсэн сургалтад суулгах, ёс зүйн сургалт хөтөлбөрт хамруулах зэрэг шүүхээс зөвшөөрсөн олон төрлийн хөтөлбөр үүнд багтдаг. Энэ журмаар сахилгын хэргийг шийдвэрлэхийн тулд дараах хүчин зүйлсийг харгалзана: 1/Америкийн хуульчдын холбооноос гаргасан стандартын дагуу тухайн зөрчилд сануулах, тэнсэн хяналт тавихаас хүнд шийтгэл оногдуулахааргүй, 2/тухайн тусгайлсан хөтөлбөрт хамрагдах нь хуульчид ач холбогдолтойн зэрэгцээ хөтөлбөрийн зорилгод нийцэх, 3/ хүндрүүлэх болон хөнгөрүүлэх нөхцөл байдал, 4/ өмнө тусгайлсан хөтөлбөрт хамрагдсан эсэх. Дээрх хүчин зүйлсийг харгалзан сахилгын зөвлөх нь тухайн хуульчтай гэрээ байгуулах бөгөөд тусгайлсан хөтөлбөрт хамрагдах хугацаанд ирсэн гомдлыг түр түдгэлзүүлнэ. Хэрэв хуульч нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчвөл гомдлыг сэргээж, сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулна.

3.3. ЯПОН УЛС

Өмгөөлөгчийн сахилгын зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагааг тус улсын “Өмгөөллийн тухай хууль”-ийн VIII бүлэгт хуульчилжээ. Өмгөөлөгч, эсхүл өмгөөллийн хуулийн этгээд нь тус хууль, Хуульчдын холбооны дүрэм, холбооны болон өмгөөлөгчийн нэр хүндэд харшлах үйлдлийг мэргэжлийн үйл ажиллагааны хүрээнд болон түүнээс гадуур хийсэн бол сахилгын шийтгэл хүлээнэ.⁷⁸

⁷⁷ Мөн тэнд, тайлбар хэсэг.

⁷⁸ Япон Улсын Өмгөөллийн тухай хуулийн 56 (1). https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3636/en#je_ch9

3.3.1. Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх институт, сахилгын шийтгэлийн төрөл

Өмгөөлөгч болон өмгөөллийн хуулийн этгээдэд уг шийтгэлийг харьяалах холбоо оногдуулна.⁷⁹ Өмгөөлөгчдийн холбоо болон Японы өмгөөлөгчдийн холбооны дэргэд сахилгын хороо (disciplinary committee), сахилгын арга хэмжээний хороо (disciplinary actions committee) тус тус ажилладаг.

Сахилгын хорооны хувьд өмгөөлөгч сахилгын зөрчил үйлдсэн эсэхийг мөрдөн шалгах, өмгөөлөгч, өмгөөллийн хуулийн этгээдийн сахилга хариуцлагатай холбогдсон бусад чиг үүргийг хэрэгжүүлдэг.⁸⁰ Сахилгын хороо нь дөрвөөс доошгүй гишүүнтэй байх ба гишүүдийн тоог тухайн холбооны дүрмээр тогтооно. Сахилгын хорооны гишүүнийг тус холбооны гишүүн өмгөөлөгч, шүүгч, прокурор болон туршлагатай хуульчдаас сонгон Ерөнхийлөгч томилно.⁸¹ Хорооны даргыг гишүүд дотроосоо сонгоно. Сахилгын хэргийг мөрдөн шалгах чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий дэд хороог мөн байгуулж болно.⁸² Сахилгын хороо нь мөрдөн шалгах чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээндээ гомдолд холбогдсон өмгөөлөгч, гомдол гаргасан этгээд, холбогдох хүн, төрийн болон бусад байгууллагаас тайлбар мэдүүлэг авах, нотлох баримт гаргуулах хуулиар олгосон бүрэн эрхтэй.⁸³

Сахилгын арга хэмжээний хороо нь өмгөөлөгчдийн холбооны дэргэд байгуулагдах ба өмгөөлөгчид оногдуулах сахилгын арга хэмжээний талаар холбогдох материалыг нягтлан шалгаж шийдвэр гаргах үндсэн чиг үүрэгтэй.⁸⁴ Тус хороог дөрөв буюу түүнээс дээш гишүүний бүрэлдэхүүнтэйгээр өмгөөлөгчдийн холбооноос шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн бүрэлдэхүүнтэйгээр хоёр жилийн бүрэн эрхийн хугацаатайгаар байгуулна. Дээрхтэй адилаар сахилгын хэргийг хянан шийдвэрлэх дэд хороог байгуулж болно.

⁷⁹ Мөн тэнд, 56 (2).

⁸⁰ Мөн тэнд, 70 (2).

⁸¹ Мөн тэнд, 70-3 (1).

⁸² Мөн тэнд, 70-6 (1).

⁸³ Мөн тэнд, 70-7.

⁸⁴ Мөн тэнд, 65 (1) (2).

Японы өмгөөлөгчдийн холбоонд Сахилгын хяналтын хороо мөн ажиллана. Орон нутгийн өмгөөлөгчдийн холбооноос тухайн өмгөөлөгчид сахилгын шийтгэл ногдуулахгүй гэж шийдвэрлэсэн, уг шийдвэрийг эс зөвшөөрч эсэргүүцэл гаргасан боловч Японы өмгөөлөгчдийн холбоо хэрэгсэхгүй болгосон тохиолдолд асуудлыг уг хороо эцэслэн шийдвэрлэнэ. Тус хороог Японы өмгөөлөгчдийн холбооны Ерөнхийлөгч хоёр жилийн бүрэн эрхийн хугацаатайгаар байгуулдаг.

Өмгөөлөгчид оногдуулах сахилгын шийтгэл нь дараах дөрвөн төрөлтэй байна.⁸⁵

- Сануулах;
- Хоёр жил хүртэл хугацаагаар эрхийг түдгэлзүүлэх;
- Холбооны гишүүнчлэлээс гарахыг даалгах;
- Холбооны гишүүнчлэлээс хасах.

Өмгөөллийн хуулийн этгээдийн хувьд дараах сахилгын шийтгэлийг оногдуулна:

- Сануулах;
- Хоёр жил хүртэл хугацаагаар үйл ажиллагааг түдгэлзүүлэх;
- Холбооны гишүүнчлэлээс гарахыг даалгах;
- Холбооны гишүүнчлэлээс хасах.

Сахилгын зөрчлийг гаргаснаас хойш 3 жил өнгөрсөн бол сахилгын хэрэг үүсгэхгүй.⁸⁶

3.3.2. Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

Өмгөөлөгч, эсхүл өмгөөллийн хуулийн этгээд нь сахилгын зөрчил гаргасан гэж үзвэл түүний харьяалах холбоонд гомдол гаргаж болно. Гомдолд тухайн зөрчлийг үйлдсэн гэж үзэж буй үндэслэлээ дурдсан байна.⁸⁷

⁸⁵ Мөн тэнд, 57 (1).

⁸⁶ Мөн тэнд, 63.

⁸⁷ Мөн тэнд, 58(1).

Сахилгын хэрэг үүсгэн шалгах ажиллагаа нь дээр дурдсан гомдлоор болон Өмгөөллийн холбооны өөрийн санаачилгаар явагдаж болно. Сахилгын хэрэг үүсгэн шалгах нь зүйтэй гэж үзвэл сахилгын хороогоор дамжуулан шалгалтын ажиллагааг явуулна.⁸⁸ Сахилгын хороо нь асуудлыг шалгаад сахилгын арга хэмжээ авах шаардлагатай гэж үзвэл тогтоол гаргаж, Сахилгын арга хэмжээний хороонд шилжүүлнэ. Энэ тохиолдолд Өмгөөлөгчдийн холбоо нь асуудлыг тус хороогоор шийдвэрлүүлнэ.⁸⁹

Сахилгын арга хэмжээний хороо нь холбогдох материалыг нягтлан шалгаад тухайн өмгөөлөгчид сахилгын шийтгэл ногдуулах нь зүйтэй гэж үзвэл тогтоол гаргана. Уг тогтоолд сахилгын шийтгэл ногдуулах үндэслэлийг тодорхой тусгана.⁹⁰ Сахилгын арга хэмжээний хороо сахилгын хэргийг хуралдаанаар шийдвэрлэх ба хуралдаанд буруутгагдаж буй өмгөөлөгч, эсхүл өмгөөллийн хуулийн этгээдийн гишүүнийг оролцуулна.⁹¹ Шаардлагатай гэж үзвэл гомдолд холбогдсон өмгөөлөгч, холбогдох этгээд, гомдол гаргагч, төрийн болон бусад байгууллагыг оролцуулж, тайлбар мэдүүлэг гаргуулж болно.⁹² Өмгөөлөгчид сахилгын арга хэмжээ авахаар тогтоол гаргасан тохиолдолд үндэслэлийг тусгасан мэдэгдлийг нэн даруй бэлтгэнэ.⁹³ Сахилгын арга хэмжээний хорооноос өмгөөлөгчид сахилгын шийтгэл ногдуулах нь зүйтэй гэсэн тогтоол гаргасан тохиолдолд сахилгын арга хэмжээг Өмгөөлөгчдийн холбоо хэрэгжүүлнэ.⁹⁴

Өмгөөлөгчдийн холбоо нь сахилгын шийтгэл ногдуулах үндэслэлгүй гэж үзсэн, зохих хугацаанд шийдвэрлээгүй, эсхүл оногдуулсан шийтгэл нь хэт зөөлөн байгаа тохиолдолд Японы өмгөөлөгчдийн холбоонд уг шийдвэр гарснаас хойш 60 хоногийн дотор

⁸⁸ Мөн тэнд, 58(2).

⁸⁹ Мөн тэнд, 58(3).

⁹⁰ Мөн тэнд, 58(5).

⁹¹ Мөн тэнд, 67 (1).

⁹² Мөн тэнд, 67 (3).

⁹³ Мөн тэнд, 67 (2).

⁹⁴ Мөн тэнд, 58 (6).

эсэргүүцэл гаргаж болно.⁹⁵ Японы өмгөөлөгчдийн холбооны Сахилгын хороо асуудлыг нягтлан шалгаад тухайн орон нутгийн өмгөөлөгчдийн холбооны сахилгын шийтгэл оногдуулахаас татгалзсан шийдвэрийг хүчингүй болгож, дахин хянан шийдвэрлүүлэхээр буцааж болно. Японы өмгөөлөгчдийн холбооноос хүсэлтийг нь хангаагүй тохиолдолд эцсийн шатны журмаар тус холбооны Сахилгын хяналтын хороонд хандан 30 хоногийн дотор гомдол гаргаж болно. Тус хороо асуудлыг хянан үзээд орон нутгийн өмгөөлөгчдийн холбоо руу шилжүүлж дахин шийдвэрлүүлэх шийдвэр гаргаж болно.

Харин оногдуулсан сахилгын шийтгэлийг үндэслэлгүй гэж үзсэн тохиолдолд Японы өмгөөлөгчдийн холбоонд хандан гомдол гаргаж болох ба уг гомдлын дагуу Японы өмгөөлөгчдийн холбооны дэргэдэх Сахилгын арга хэмжээний хороо асуудлыг нягтлан шалгаж захиргааны журмаар шийдвэр гаргана.⁹⁶ Дээрх байдлаар захиргааны журмаар шийдвэрийг хянуулахаар гаргасан хүсэлт нь хангагдаагүй тохиолдолд тус холбооны шийдвэрийг давж заалдан Токио хотын дээд шүүхэд гомдол гаргаж болно.⁹⁷

Өмгөөлөгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг АНУ, ХБНГУ, Япон улсуудын түвшинд харьцуулан авч үзлээ. Энэ хүрээнд дараах нийтлэг дүгнэлтийг хийж болохоор байна.

Сахилгын хэргийг нотлох, мөрдөн шалгах (investigation) ажиллагаа нь хэрэгт хамааралтай нотлох баримтыг цуглуулах, гомдолд холбогдсон хуульч, өмгөөлөгчид албан ёсоор мэдэгдэх, гэрчээс мэдүүлэг авах, шинжээчээр дүгнэлт гаргуулах зэрэг цогц ажиллагаа байна. Үүнтэй холбоотойгоор судалгаанд хамрагдсан аль аль улсын хувьд мөрдөн шалгах ажиллагаанд нотлох баримт цуглуулах эрх хэмжээг хуулиар тусгайлан олгожээ. Жишээ нь Япон улсад энэхүү чиг үүргийг хэрэгжүүлж буй субъектыг Эрүүгийн хуульд заасан нийтийн албан тушаалтантай адилтган үздэг.

⁹⁵ Мөн тэнд, 64 (1).

⁹⁶ Мөн тэнд, 59.

⁹⁷ Мөн тэнд, 61 (1).

Түүнчлэн мөрдөн шалгах ажиллагааны эцсийн зорилго нь үйлчлүүлэгч болон өмгөөлөгч хоорондын маргааныг шийдвэрлэх гэхээс илүүтэй өмгөөлөгчид итгэх олон нийтийн итгэлийг бэхжүүлэх үндсэн зорилготой тул шалгах эрх бүхий субъектэд өөрийн санаачилгаар шалгалтын үйл ажиллагаа явуулах эрх хэмжээ олгогдсон байна. Сахилгын процессын өөрийнх нь онцлог, мөрдөн шалгах эрх бүхий субъект санаачилгаараа хэрэг үүсгэн шалгах эрхтэй байдаг зэргээс үзвэл шалгах хүрээ нь зөвхөн гомдлоор хязгаарлагддаггүй байна.

Өмгөөлөгчийн ёс зүйн зөрчлийг шалгах, нотлох, шийдвэрлэх, давж заалдах журмаар хянах зэрэг чиг үүргийг өөр өөр субъектэд хуваарилах замаар процессын шударга ёсны зарчмыг хангаж байгааг анхаарах хэрэгтэй. Жишээ нь АНУ-д сахилгын зөвлөх шалгах, нотлох чиг үүргийг, Сахилгын хэргийг хянан хэлэлцэх хороо нь түүнийг хянаж саналаа гаргах, Сахилгын хороо нь давж заалдах журмаар хянах, эцсийн шийдвэрийг шүүх гаргах зэргээр чиг үүргийг хуваарилсан. Японд мөрдөн шалгах чиг үүргийг сахилгын хороо, шийдвэрлэх үүргийг сахилгын арга хэмжээний хороо, давж заалдах журмаар хянах чиг үүргийг Японы өмгөөлөгчдийн холбоо, улмаар шүүх хэрэгжүүлж байна.

Сахилгын шийтгэл ногдуулах хөөн хэлэлцэх хугацааг ялгамжтай тогтоож байгааг мөн анхаарах хэрэгтэй. АНУ, ХБНГУ-д хөөн хэлэлцэх хугацаа байхгүй бол Японд 3 жилээр тогтоосон байна.

Аль аль улсад эцсийн шийдвэрийг шүүх гаргах буюу шүүхийн хяналтад асуудлыг эцэслэн шийдвэрлэж байгаа нь шүүхэд хандах иргэний үндсэн эрхийг баталгаажуулсан хэлбэр байна.

ДҮГНЭЛТ

Өнөөгийн ардчилсан, эрх зүйт нийгэмд хуулийг амьдралд, иргэдэд ойртуулах, тайлбарлан ойлгуулах нийгмийн харилцааны гол хүчин зүйл буюу “инженер” нь болох хуульч, өмгөөлөгч үндэсний ёс зүй, ёс суртахууны ариун нандин, үнэт өв уламжлалыг дээдлэн, үнэ цэнтэй амьдрах боломжийг иргэн бүрт олгох, шударга нийгмийг бүтээх үүрэг хүлээсэн мэргэжил гэдгээрээ ёс зүй, ёс суртахууны хувьд өндөр хариуцлага хүлээдэг.

Өмгөөлөгч нь өмгөөллийн үйл ажиллагаандаа ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллахыг чухалчлан, тангараг өргөж үйл ажиллагаа явуулах эрхээ баталгаажуулдаг. Энэ нь хүний эрхийг хууль ёсны дагуу шүүхэд төлөөлөн хамгаалах эрх бүхий этгээдийн үүргийг нийгмийн өмнө хүлээж, хууль тогтоомжоор нарийвчлан заагаагүй ч хуулиар зохицуулагдаж хуулийн ерөнхий заалтад тулгуурлан ёс зүйн хэм хэмжээнд захирагдан ажилладаг байна.

Үндсэн хуульдаа хүний эрхийг хамгаалах, өмгөөлөл, хууль зүйн туслалцаа үзүүлэх чиг үүргийг хуульчилж, хэрэгжүүлэх болсон цагаас өмгөөлөгчдийн ёс зүй, мэргэжлийн хариуцлагын асуудал нийгмийн бүхий л цаг үед олон нийтийн анхаарлын төвд байжээ. Хүний эрхийг хангасан сайн хууль, шударга нийгэм бий болоход өмгөөлөгчид төдийгүй хуульчид онцгой үүрэгтэй байх бөгөөд хууль зүйн салбарын нэр хүнд үүнтэй шууд холбоотой байдаг. Өмгөөлөгч гэх мэргэжлийг дагаад хариуцлага хүлээлгэх бүтэц нийгмийн хөгжлийн цаг үе бүхэнд ажиллаж, өмгөөлөгчдийн ёс зүй, мэргэжлийн хариуцлагатай холбоотой өргөдөл, гомдлыг шийдвэрлэж ирсэн ба ихэвчлэн үйлчлүүлэгчийн гомдлоор үүсэхдээ тэдний эрхийн зөрчилтэй холбоотой үүсдэг байна.

Өмгөөлөгчийн ёс зүйн зөрчлийг шалгах, нотлох ажлыг шинжээч гүйцэтгэж маргаан хянан шийдвэрлэх явцад хорооны гишүүд эцсийн шийдийг хурлаараа гаргадаг. Мөн давж заалдах журмаар хянах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг байгаа нь хэлбэрийн хувьд бусад улстай ижил байна. ХБНГУ-д сахилгын шүүх, АНУ-д Сахилгын

хэргийг хянан хэлэлцэх хороо, Японд мөрдөн шалгах чиг үүргийг сахилгын хороо, шийдвэрлэх үүргийг сахилгын арга хэмжээний хороо нь өмгөөлөгчид итгэх олон нийтийн итгэлийг бэхжүүлэх үндсэн зорилготой тул үйлчлүүлэгч болон өмгөөлөгч хоорондын маргааныг шийдвэрлэхдээ шударга ёсны зарчмыг хангаж иргэний үндсэн эрхийг баталгаажуулахад чиглэдэг.

Манай улс нэгдэн орж, соёрхон баталсан олон улсын гэрээ, конвенцод өмгөөлөл, хууль зүйн туслалцаа үзүүлэх, иргэдийн эрх, эрх чөлөөг хангах, тэгш эрх шударга ёсыг дэмжсэн олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөх үүрэг хүлээсэн төдийгүй дотоодын хуульд тусгах замаар хэрэгжилтийг хангах, батлагдан гарч буй хууль тогтоомж бүр хүний эрхийг хангахад чиглэсэн байх бол төрөөс хууль хэрэглэх иргэдийн эрхийг хангахад чиглэсэн ажлыг зохион байгуулан дүрэм журам хэлбэрээр нарийвчилсан зохицуулалтыг баталж хэрэгжилтийг хангадаг. Өмгөөлөгчийн ёс зүй, нэр хүнд иргэдийн дунд алдагдахад ёс зүйгүй өмгөөлөгчдийн үйлдлээс гадна хууль хоорондын уялдаа холбоог хангах, эрх зүйч болон бусад хуульчдын ёс зүйн хариуцлагын асуудлыг зохицуулсан зохицуулалт дутмаг байгаа нь нөлөөлж байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

- 1/ Өмгөөллийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, эрх зүйн орчин шинэчлэгдэн холбогдох дүрэм, журам батлагдах хүртэлх 2 жилийн хугацаанд буюу хууль болон холбогдох дүрэм, журам батлагдах, хэрэгжиж эхлэх хүртэлх хуулийн хугацаанд өмгөөлөгчийн ёс зүй, хариуцлагын асуудалтай холбоотой өргөдөл, гомдол шийдвэрлэх боломжгүй болдог байна. Иймд энэ хугацааны өргөдөл гомдлыг тасалдуулахгүй тал дээр холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас анхаарах;
- 2/ Өмгөөллийн байгууллага 100 орчим жилийн түүхтэй хэдий ч бүртгэл, мэдээллийг цэгцлэх, архивлах, ажлыг хийснээр хувь хүний хөгжил, ёс зүй, ёс суртахууныг дэмжих төдийгүй, олон жилийн хугацаанд мэргэжлийн ёс зүйн хариуцлага хүлээж байгаагүй өмгөөлөгчийг өргөмжлөх, урамшуулах, мэргэшсэн өмгөөлөгчийг тодруулах зэргээр байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлэх;
- 3/ Мэргэжлийн хариуцлагын хорооноос маргаан шийдвэрлэх процесс, шийдвэрлэсэн байдлын талаар мэдээлэл тодорхойгүй байгаа нь иргэд, үйлчлүүлэгчийн зүгээс хариуцлагагүй өмгөөлөгчдийн талаарх олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацагдаж буй сөрөг мэдээлэлд суурилсан дүгнэлт хийх, хуулийн байгууллага, хуульчдад итгэх итгэл буурах зэрэг сөрөг үр дагавар гарч байна. Иймд нийт өмгөөлөгчдийн нэр хүндийг олон дахин унагаад байгаа хариуцлагагүй, ёс зүйгүй болох нь тогтоогдсон, олон дахин арга хэмжээ авагдаж байсан бол тухайн өмгөөлөгчийн эрхийг хүчингүй болгох; нийтэд ил болгох зайлшгүй шаардлагатай тоон мэдээллийг цаг тухай бүр нээлттэй байлгах; нийт өмгөөлөгчид ёс зүйн алдаа гаргахгүй байхад анхаарал хандуулах;

- 4/ Судалгааны явцад өмгөөлөгчөөс хууль зүй, өмгөөллийн үйлчилгээ авсан иргэдээс судалгаа авч нэгтгэн дүгнэхэд өмгөөлөгчийн ёс зүй, мэргэжлийн ур чадвар, хариуцлагын асуудалд сэтгэл дундуур, шүүмжтэй хандаж байх тул өмгөөлөгч бүр ёс зүйтэй, ур чадвартай, хариуцлагатай байхад хөшүүрэг болохуйц арга хэмжээг хэрэгжүүлэх замаар зэрэг олгох, урамшуулах буюу хариуцлагажуулах ажлыг эрчимжүүлэх;
- 5/ Өмгөөлөгчдийн ёс зүй, хариуцлагатай холбоотой хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актыг хэрэгжүүлэхдээ өмгөөлөгчдийн ёс зүй, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх, өмгөөлөгчийн ажил мэргэжлийн онцлогийг олон нийтэд таниулах замаар чадвартай өмгөөлөгчдийн нэр хүндийг сэргээх, авлига, хээл хахууль, танил тал барьж асуудлыг шийддэг, хоёр талд үйлчилдэг, мөнгөгүй бол муу өмгөөлж, мөнгөтэй бол сайн өмгөөлнө зэрэг нийгэмд үүссэн сөрөг хандлагыг залруулах шаардлага байна.
- 6/ Засаглал нь тэнцвэртэй, авлига үгүй улсад ёс суртахууны эерэг хандлага давамгайлж гэмт хэрэг буурч байдаг. Улс бүр хөгжлийн түвшин, хэрэгцээ шаардлагад тохирсон олон талт харилцааг зохицуулах хууль, дүрэм, журмыг боловсруулан баталж баримтлах, хэвшүүлэх, дадал болгох нь ёс зүйгээс үүдэлтэй байх тул Монголын Өмгөөлөгчдийн холбооноос хуулийн хэрэгжилтийг хангах, батлагдсан дүрэм, журмын хэрэгжилтэд мониторинг хийх, үнэлж дүгнэх, өөр хоорондын уялдаа холбоог хангах, давхардсан, зөрчилдсөн, зохицуулагдаагүй харилцаа байгааг нөхөх, мэргэжлийн хариуцлагын хорооны хяналт шалгалт, шинжээчийн ажлын байрны бүтэц зохион байгуулалтад анхаарах шаардлагатай.
- 7/ Монголчууд хүний дотоод сэтгэлтэй нягт холбоотой бичмэл биш, хуулийн хэлбэрээр өв залгамжлагдан, цаг үеийнхээ аяар шинэчлэгддэг ёс суртахууны ариун нандин, үнэт өв уламжлалыг олон зуун жил өвлүүлж, хөгжүүлж ирсэн түүхэн уламжлалтай байх тул Хуульчдын холбооны зүгээс

эрх зүйн сургалтаар суралцаж буй оюутанд орох хичээлийн агуулгад ёс зүй, ёс суртахууны хичээлийн багц цагийг нэмэгдүүлэхэд анхаарах, хуульч болох шалгуурт хувь хүний хөгжил төлөвшилд оноо өгдөг байх, төстийн хэлбэрээр бус хувь хүний хөгжлийг аман хэлбэрээр шалгаж авдаг болох зэргээр ёс зүй, ёс суртахууны төлөвшил сайтай хуульч хүнийг бэлтгэх шалгуурыг нэмэгдүүлэх нь шударга нийгмийг бүтээх ач холбогдолтой.

- 8/ Иргэдийн зүгээс ирсэн хуульчдын ёс зүйгүй асуудалд хариуцлага тооцох, иргэдийн зүгээс нийт хуульчдад ирж буй гомдлыг барагдуулах ажлыг зохион байгуулах, эрх зүйч болон бусад хуульчдын иргэдийг төлөөлөх ёс зүйн асуудалд хяналт тавих нь Хуульчдын холбооны ажлыг бэхжүүлээд зогсохгүй нийт хуульчдын нэр хүндийг өсгөх, иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Хууль, хуульчилсан акт

1. Өмгөөллийн тухай хууль, 2019.
2. Монголын өмгөөлөгчдийн холбооны дүрэм, 2020.

Ном, бүтээл, эрдэм шинжилгээний өгүүлэл

3. Ж.Амарсанаа нар, Хууль зүйн тайлбар толь, 2003.
4. Ж.Амарсанаа, Англи, Орос, Герман-Монгол олон улсын эрх зүйн толь, 2004.
5. Ж.Бямбаа, Өмгөөллийн шинэтгэл, Өмгөөлөл судлал (Өгүүлэл, нийтлэлийн эмхэтгэл) Нэгдүгээр боть, 2015.
6. Б.Галиндэв, “Нийгмийн ёс суртахуун институци болох нь” сэдэвт илтгэл, Монгол Улс дахь хуульчдын ёс зүйн тулгамдсан асуудал, Эрдэм шинжилгээний бага хурал, 2019.
7. Б.Чимид, Төр, нам эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудал, Хоёрдугаар дэвтэр, 2008.
8. Б.Чимид, Үндсэн хуулийн мэдлэг, 2008.
9. Г.Жаргал, Н.Сэлэнгэ, Ёс суртахууны зохицуулалтын агуулга, аргын өөрчлөлт, “Хууль дээдлэх ёс” Цуврал 1 (76), Хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгаа, практикийн улирал тутмын сэтгүүл, 2020.
10. Ж.Хунан, “Монголын хуульчийн ёс зүйн онол-практикийн зангилаа асуудалд” сэдэвт илтгэл, Монголын хуульчдын ёс зүй (тулгамдсан асуудал), Эрдэм шинжилгээний бага хурлын өмнөх үг, 2019.
11. М.Золзаяа, Ёс зүй, 2014.
12. Монголын хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны шийдвэрийн эмхэтгэл, Хуульчийн ёс зүйн зөрчил, шийдвэрлэлтэд хийсэн дүн шинжилгээ, судалгаа, 2018.

13. О.Пүрэв, “Боловсролын ёс зүй ба шинэ үеийнхний танин мэдэхүй, ёс суртахууны онцлог” сэдэвт илтгэл, Монгол дахь боловсролын философийн асуудал, хандлага, Эрдэм шинжилгээний хурал, 2022.
14. П.Долгор, Өмөөрөхийн заяат хүмүүний санаа зөв байх ёстой, Өмгөөлөл судлал (Өгүүлэл, нийтлэлийн эмхэтгэл) Нэгдүгээр боть, 2015.
15. П.Пүрэвням, Монголын Өмгөөлөгчдийн Холбооны ерөнхийлөгч Өмгөөлөл судлал (Өгүүлэл, нийтлэлийн эмхэтгэл) Нэгдүгээр боть, 2015.
16. Р.Вандангомбо, Ёс зүй, хууль, Монголын Өмгөөлөгчдийн Холбоо “Эрх зүйн мэдлэг” цувралын эхний дугаар, 1997.
17. С.Мягмарсүрэн, “Өмгөөлөгчдийн холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны бүрэлдэхүүний талаарх тулгамдсан асуудал” илтгэл, 2022.
18. С.Нарангэрэл, “Хуульчийн мэргэжилдээ үнэнч байх чанар” лекц, 2016.06.20.
19. С.Нарангэрэл, “Монголын хуульчийн ёс зүйн онол-практикийн зангилаа асуудалд” сэдэвт илтгэл, Монголын хуульчдын ёс зүй (тулгамдсан асуудал), Эрдэм шинжилгээний бага хурал, 2019.
20. С.Нарангэрэл, Эрх зүйн толь бичиг, 2008.
21. Хуульчийн ёс зүй (гарын авлага), 2013.
22. Ч.Нямсүрэн, Эрх зүй, төрийн ерөнхий онол, 2004.
23. Ш.Дуламсүрэн, Хуульчийн мэргэжлийн ёс зүй, 2007.
24. Я.Нямжав, Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох нь, Монголын Өмгөөлөгчдийн Холбоо “Эрх зүйн мэдлэг” цувралын эхний дугаар, 1997.

Гадаад улсын хууль тогтоомж

25. Америкийн нэгдсэн улсын Холбооны хуульчдын тухай хууль.
26. Япон Улсын Өмгөөллийн тухай хууль.
27. Япон Улсын Хуульчийн сахилгыг сахиулах загвар журам.

Цахим эх сурвалж

28. Монгол хэлний их тайлбар толь, 2015. Монгол хэлний их тайлбар толь (mongoltoli.mn)
29. Б.Лхагвасүрэн, “Хуульчид бол тэнгэрийн томилгоотой хүмүүс”. <https://advocate.mn/news/73/single/96>
30. Юрген Харбих, Эрх зүйт, ардчилсан төрд хуульчийн гүйцэтгэх үүрэг. Эрх зүйт, ардчилсан төрд хуульчийн гүйцэтгэх үүрэг (conscourt.gov.mn)
31. Ching-Hung Woo, Einstein’s Morality, 2015. https://philosophynow.org/issues/109/Einsteins_Morality

ХАВСРАЛТ

ХАВСРАЛТ 1. “МОНГОЛ ҮНДЭСНИЙ ЁС СУРТАХУУНЫ ҮНЭТ ӨВӨӨС”⁹⁸

№	Монгол ёс суртахууны үнэт зүйл	Агуулга
1	Ажил хөдөлмөр, эрдмийг эрхэмлэх	Ажил үйлийн дүнд хүн болно. Эрдэм ухаан бие, сэтгэлийг чимнэ.
2	Үнэнч, шударга	Нэг эшт сэтгэл, эрх тэгш хандлага
3	Эр зориг	Аливаа үйлд өөрийг дайчлах сэтгэл, оюуны эрч, сэтгэлийн хат
4	Ичих, эмээх	Хүний сэтгэлийн гүн гэмших мэдрэмж
5	Үүрэг хариуцлага	Хийх ёстой зүйлдээ чин сэтгэлээс хандаж, чанартай үйлдэх (Аливаа үйлийг миний хийх зүйл хэмээн хандаж, үр дүн гаргах)
6	Нэр төр	Хүмүүний эн тэргүүнд эрхэмлэж, сэвтээхгүй байх үнэт зүйл
7	Итгэл	Сэтгэл, оюуны бат үнэмшил
8	Нинж нигүүлсэнгүй	Бүхнийг энэрэх
9	Уужим, өгөөмөр	Чин сэтгэлээс асрах, ачлах сэтгэлээр бүхэнд туслах
10	Жудаг, мүс	Ноён нуруу, хүн чанар
11	Тэсвэр тэвчээр	Аливаа үйлд хүлээцтэй, сэтгэлийн тэнхээтэй байх
12	Эе эв	Зохицол, нийцэл, хамтач байдлын эрхэмлэл
13	Үл хомхойрох	Эс шунахайран ховдоглох “Шунал ихэдвэл унал ихэднэ Шуурга ихэдвэл зуд болно. Шуналаар баяждаггүй Сувдгаар таргалдаггүй” Монгол ардын зүйр цэцэн үг

⁹⁸ О.Пүрэв, “Боловсролын ёс зүй ба шинэ үеийнхний танин мэдэхүй, ёс суртахууны онцлог” сэдэвт илтгэл, Монгол дахь боловсролын философийн асуудал, хандлага, Эрдэм шинжилгээний хурал, 2022, 36 дахь тал.

№	Монгол ёс суртахууны үнэт зүйл	Агуулга
14	Атаа, өс хонзон эс өвөрлөх	Бусдын сайн үйлд эс хорсон, үл өшөөрхөх (Бусдын хотол төгс, сайн сайханд үл баясан жөтөөрхөхийг атаа гэнэ) "Ахуй их эрдэм төгссөн мэргэд атаа омоггүй урсгал номхон суух Амттай олон үрсийн хонгорцгоор чимсэн Аливаа модны үзүүр нь бөхийх буй Гүнтэн гэгээн Гончигдамийдонми "Модны шаштир" зохиол
15	Үл урвах	Аливаа зүйлд чигч нэг зангаар хандан үйлдэх
16	Найрсаг зочломтгой г.м	Элгэмсэг, хүндлэлт, зочлолт хандлага

ХАВСРАЛТ 2. ЁС СУРТАХУУНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН АГУУЛГА, АРГЫН ХАРЬЦУУЛАЛТ

Манай улсын нийгэм түүхийн нөхцөл байдал

Арга	Шалгуур үзүүлэлт	XIX зуун Хамжлагын (феодалын) харилцаа	XX зуун Нийгэм журмын (социалист) харилцаа	XXI зуун эхэн Ардчилал, зах зээлийн харилцаа
А. Соёл уламжлалд суурилсан арга	Зан үйл, шашин	Ард түмний уламжлал зан, заншил зонхилсон	Уламжлалт зан, заншилд “авах, гээхийн ухаан”-аар хандах; ОУ-д Зан үйлийн онолууд үүссэн	Эерэг, бүтээлч зан үйл хэвшүүлэх (хүндлэх, мэндлэх, зөвшилцөх,...); Зан үйлийн онолуудыг бүтээлчээр хэрэглэх
	Шашин	Буддын шашин зонхилж, бусад шашны сургаал зэрэгцсэн	Шашингүй үзлийг баримталсан ч далд хэлбэртэй байсан	Шашин шүтэх, сүсэг бишрэл нь хувь хүний эрх болсон
	Урлаг	Ардын аман зохиол (Үлгэр, туульс, Жангар, Гэсэр,...);	Дэлхийн сонгодог уран зохиол, яруу найраг, хөгжим сонсох, унших	Дэлхийн төвшинд урлаг, спортоор уралдах, оролцох, зохиох, бүтээх
	Соёл	Монгол үндэстний уламжлалт соёл	Олон соёлтой танилцах, даяарчлал эхэлсэн	Олон соёл зэрэгцэн орших, дасан зохицох болсон
В. Хувь хүний үзэл бодол	Үнэлэмж, үнэт зүйл	Хүн чанар, буян-нүглийн тухай сургаалууд	ОУ-д 1960-70 оноос судалсан; манай улсад 2000 оноос судалж бичих	Хувь хүний үнэлэмж, үнэт зүйлийг эрхэмлэх; Нийгмийн үнэт зүйлийг чухалчлах болсон
С. Эрх зүйд суурилсан арга	Төрийн удирдлага	Шашин-төр хосолсон, сүсэг бишрэлд давамгайлсан	Захиргаадалт, бюрократ (хүнд суртал), намын үзэл суртал	Төрийн захиргаа, удирдлага, засаглал
	Хууль, эрх зүй	Халх журам, Хааны зарлиг гэх зэрэг	Үндсэн хууль, бусад хууль, Мэргэжлийн ёс зүйн дүрэм, журам	Хууль, Ёс зүйн дүрэм, журмын шинэчлэлийг бусад аргатай хослуулах
Д. ШУ-ны ололт	Шинжлэх ухаан	Арван их, бага ухаан, Дорнын анагаах ухаан гэх зэрэг	ШУ-ны ололтыг нэвтрүүлэх, хэрэглэх; Эрдэмтний ёс зүй	ШУ-ны салбаруудын хамтын ажиллагаа, мэдлэг бүтээх

ХАВСРАЛТ 3. ӨМГӨӨЛӨГЧИД ХҮЛЭЭЛГЭСЭН ХАРИУЦЛАГА

Он	Өмгөөлөгчийн тоо	Хүлээн авсан гомдол	Маргаан, хэрэг үүсгэсэн	Хариуцлага хүлээлгэсэн			
				Нээлттэй, хаалттай сануулсан	Шүүхэд төлөөлөх эрхийг хугацаагүй түдгэлзүүлсэн	Хуульчийн зөвшөөрлийг хугацаагүй хүчингүй болгосон	Бүгд
2002	Өмгөөллийн тухай хууль батлагдсан						
2003	Монголын Өмгөөлөгчдийн Холбооны Их хурал зохион байгуулж, дүрмээ баталсан						
2004							
2005							
2006	45	45	42	9	2	1	12
2007	76	93	97	22	3	2	27
2008	338	143	151	63	9	81	153
2009	362						
2010							
2011							
2012	Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдсан						
2013	Хуульчдын холбооны их хурал байгуулагдсанаар дүрмээ баталсан						
2014	326	170	31	-	-	-	
2015	284	199	95	12	2	2	16
2016	376	216	97	21	2	-	23
2017	378	206	94	8	3	-	11
2018	342	179	103	13	2	-	15
2019	Өмгөөллийн тухай хууль батлагдсан						
2020	Монголын Өмгөөлөгчдийн Холбооны Их хурал зохион байгуулагдан, дүрмээ баталсан						
2021	213	213	20	13	4	1	18

